

МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

~ THE OFFICIAL GAZETTE ~

2016.12.09, БААСАН ~ №255 (533)

ҮНЭ: 600Т

ОНЦЛОХ

УЛС ТӨР

Ерөнхий сайд төсвийг хуулийн дагуу зарцуулахад хатуу хяналт тавихыг зөвлөв.
Японы Элчин сайд асан Т.Шимизү өнөөдөр эх орондоо буцлаа.
АН-ын Их хурлаас МАН-д хэд хэдэн зүйлтэй шаардлага хүргүүлжээ.
Чуулганаар Оффшорын тухай хуулийг үргэлжлүүлэн хэлэлцэх нь зүйтэй гэж үзэв.
Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг баталлаа.

ЭДИЙН ЗАСАГ

Улсын хэмжээнд хувьцаагаа гаргасан 302 хувьцаат компани бүртгэлтэй байна.
ББСБ-ууд нийт 143.3 тэрбум төгрөгийн орлоготой ажиллажээ.
Монголын хөрөнгийн биржийн индекс 0.66 хувиар буурав.
"Kinsoqa Sorper" компани 1.4 сая ширхэг хувьцаа гаргахаар болсноо мэдээллээ.
БНХАУ-ын эдийн засаг ирэх онд 6.5 хувьд хүрнэ гэж "Goldman Sachs" таамаглав.

НИЙГЭМ

Замын нөхцөл байдлын улмаас зарим аймагт мотоциклиор зорчихыг хориглолоо.
Богд хааны амьдрал, түүхэнд гүйцэтгэсэн үүргийн талаар эрдэмтэд хэлэлцүүлэг өрнүүлэв.
Хилээр их хэмжээний хөлдөөсөн мах гаргахыг завдсан этгээдийг саатуулжээ.
"Жендерийн мэдрэмжтэй эрүүл мэндийн бодлого" сэдэвт чуулган боллоо.
Монголын оюутны спортын холбоо оны шилдэг тамирчнаар М.Анхцэцгийг тодруулав.

ДЭЛХИЙ

Өмнөд Солонгосын парламентад Ерөнхийлөгчөө огцруулах асуудлыг өнөөдөр шийднэ.
Сирийн Алеппо хотын 150 гаруй хүүхэд, эмэгтэйчүүдийг байлдааны бүсээс гаргав.
Европын холбоо Украин, Гүржид визгүй зорчих эрх олгох төлөвлөгөөг сэргээлээ.
АНУ-д дундаж наслалт 1993 оноос хойш анх удаа багассан байна.
Хятадын Шинжаан мужид 13,7 км гүнд 5.9 магнитудын хүчтэй газар хөдлөв.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР
 2016.12.09

 -13° -23°
 БАГАВТАР ҮҮЛТЭЙ

ЦАГ АГААРЫН ДЭГЭРЭЖИГҮЙ МЭДЭЭЛИЙГ
 8 ДУГААР НУУГУУС ҮНИШНА УУ.

 Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

Хүнсэнд нуусан “тэсрэх бөмбөг”



Дэлхийн эрүүл мэндийн байгууллага 2020 он гэхэд улс орнуудын транс тосны хэрэглээг бүрмөсөн хориглохоор төлөвлөжээ. >3

Улстөр Их хурлын хүлээлт талаар болов

Намын даргын сунгаанд өрсөлдөх гишүүдэд ямар нэгэн шалгуур тавихгүй

Б.Даваатогтох
 @datoZGM

Сонгуульд ялагдал хүлээн гашуун сургамжаасаа ухаарч, намдаа шинэ уур амьсгал оруулахаар хуралдсан Ардчилсан намын Их хурал нэлээд халуухан өндөрлөлөө. Үндсэн дүрэмдээ өөрчлөлт оруулахаар зэхсэн ч гишүүдийн

шүүмжлэл, саналын зөрчилдөөнтэй тулгарсан тул дараагийн Их хурал руу төслөө шилжүүлэхэд хүрэв. Энэ хүрээнд шинэчилсэн дүрмийн төслөө намын бүх шатанд хэлэлцүүлээд VII Их хурлаараа батлахаар болсон юм. Гэхдээ Ажлын хэсгээс боловсруулсан дүрмийн төслийн тал хувь дээр нь санал нэгдсэн байна. Энэ талаар Ардчилсан намын дарга З.Энхболд “Их хурлыг зохион байгуулах Ажлын хэсэг болон ҮЗХ намын дүрмийг шинэчилж, батална хэмээн төлөвлөж байсан. >2

Урлаг Балет гэдэг олон дундаас цөөхөн нь гялалздаг урлаг

Г.Сайнзаяа
 @sainzayaZGM


УДБЭТ-ын гоцлол бүжигчин А.Эрдэнэболдтой ярилцлаа. Тэрбээр “Жизель”, “Цөмөөхэй”, “Хунт нуур”, “Копэлиа”, “Диана”, “Акцион хоёр”, “Их классикүүд” зэрэг бүхий л жүжигт гол дүр бүтээж яваа, гал цогоор гялалзсан залуу уран бүтээлч. Түүнтэй анх уулзахад “Би тоглолтын талаар ярилцлага өгч байснаас өөрийнхөө тухай ярьж үзсэнгүй” хэмээв. Ухаалаг харц, эрхэмсэг төрх, дулаахан царайтай тэрбээр ханхүүгийн дүрд яг тохирдог юм байна >7

гэж бодмоор. Ийнхүү түүнтэй ярилцлаа.
-Сонгодог урлагийн сор болсон жүжгүүдэд гол дүр бүтээдэг А.Эрдэнэболдын талаар яриагаа эхлэх үү?
 -Ажил хийж яваа энгийн л нэг залуу хүн шүү дээ, би. Ажилдаа ирэхдээ, явахдаа цаг бүртгэлийн машинд хуруугаа уншуулж, цалингаас картаар авдаг жирийн залуу. Өглөө талх, масло идээд гарна, орой тараад найз охин руугаа яарна. Бусдын л адил ажил хийж, мөнгө олж, сэтгэлээр унаж, урмын үгээр тэтгэгдэж, инээж баярлаж явна. >7

ЭДИЙН ЗАСАГ Экспортыг эрчимжүүлэх хөтөлбөртэй танилц

Б.Баяртогтох
 @bayartogtokhZGM

Эдийн засгийн хүндрэлийг даван туулах хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төслүүд тодорч эхэлсэн. Үүний нэг нь “Зэс” хөтөлбөр. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгааг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас онцлох байна. “Монгол зэс” хөтөлбөр нэрээр энэ хөтөлбөрийг 2014 онд эхлүүлж байсан. Зэсийн баяжмалын экспортыг нэмэгдүүлэх нь уг хөтөлбөрийн гол зорилго. Хөтөлбөрийг боловсруулах суурь судалгааны ажил хийгдсэн бөгөөд улам сайжруулах юм. Сүүлийн зургаан жилийн хугацаанд геологийн судалгааны ажлын үр дүнд зэсийн 80 орчим илрэл, 300 гаруй эрдэсжсэн цэгийг тогтоосон байдаг. Эдгээр илрэл, цэгт цаашид нэмэлт хайгуулын судалгаа хийх шаардлагатай аж. Ингэснээр ашиглах боломжтой эсэхийг судлах юм. Хэрэв орд шинээр илэрсэн тохиолдолд хайгуулын судалгааны ажил улам гүнзгийрч, техник, эдийн засгийн үнэлгээ хийнэ гэсэн үг. Энэ нь хайгуулын салбарт гадаадын шууд хөрөнгө оруулалт татах хөшүүрэг. Зэсийн баяжмалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх нь экспортын орлого өсөх боломж юм. Үүнийг төсвийн орлого нэмэгдэх гарцуудын нэг гэж болно. >11



MSE ALL 786.85 0.66%	АЛТ 1174.20 0.08%	ЗЭС 5785 1.6%	10-ЧИНГИС БОНД 87.640 0.06%	5-ЧИНГИС БОНД 95.930 0.09%	АМ.ДОЛЛАР 2474.86	ЮАНЬ 359.17	РУБЛЬ 38.73
-----------------------------------	--------------------------------	----------------------------	--	---	-----------------------------	-----------------------	-----------------------

Нийтлэлчийн булан

Дэлхий нийт транс тосноос татгалзаж байхад Монгол чимээгүй байж боломгүй

Б.Гандолгор
@gandolgorZGM

Олон хэрэглэгчийн хүнсэн дотор удаан хугацаанд тэсрэх бөмбөг нуугдсан байдаг гэвэл та итгэхгүй биз. Гэвч энэ үнэн билээ. Өдгөө бөмбөрцгийн хүн төрөлхөнд транс тосны аюул нүүрлэд байна. Хүнсний бүтээгдэхүүн тэр дундаа пицца, гамбургер, кекс, торт,

бие организм аажимдаа зогсонги байдалд орох эрсдэлтэй. Учир нь ургамлын тосыг хүний бие “ашигтай” гэсэн командаар хүлээж авдаг аж. Гэтэл ургамлын тосны усыг нь шахааж аваад хатуу хэлбэрт оруулан үйлдвэрийн аргаар боловсруулсан тохиолдолд найрлагад нь өөрчлөлт орж, хүний биед ашигтай шинж чанар нь алдагддаг. Ингэж усыг нь шахааж хатууруулсан тос хүний эсийн бүрхүүлийг гэмтээж, нэвтрэх чадварыг нь алдагдуулдаг бөгөөд биед шингэх ёстой сайн төрлийн холестерин хэмжээг бууруулдаг аж. Эсрэгээрээ муу төрлийн холестерин нь хэмжээг нэмэгдүүлдэг хэмээн судлаачид тайлбарлаж байгаа юм. Ингэснээр хүмүүс өвчинд өртөмтгий болдог. Мөн таргалалт



С.Батсайхан/ЗГМӨ

тос хэрэглэхийг хориглоогүй тохиолдолд үйлдвэрлэгчдийг буруутгах аргагүй. Иймээс хууль эрх зүйн орчноо сайжруулах шаардлага тулгарч байгаа юм.

Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн ажилтан Э.Эрдэнэцогт “Манай зах зээлд транс тосны хэрэглээ элбэг байна. Гэвч нэг өдөр хууль гаргаад, шууд хориглочихож болохгүй. Тэгвэл хүнсний ихэнх үйлдвэр дампуурна. ОХУ 2018 он гэхэд транс тосыг нэг хувь хүртэл бууруулна гэж тооцоолсон. Тэгэхээр аажмаар бууруулах зохицуулалт хэрэгтэй байна. Бид бэлчээрийн мал аж ахуйн цөцгийн тос хэрэглэдэг ард түмэн. Олон сая малынхаа буянаар органик цөцгийн тос хэрэглэх бүрэн боломжтой шүү дээ” хэмээсэн юм.

Хүнсэнд нуусан “тэсрэх бөмбөг”

жигнэмэг, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, энергийн хүнс зэргийг голдуу транс тосноор хийдэг болсныг судлаачид анхааруулсаар байгаа. Эдгээр нэрлэсэн хүнсний бүтээгдэхүүнд транс тос далд хэлбэрээр агуулагддаг тул мэдэх боломжгүй аж.

Уг нь үйлдвэрлэгчид устөрөгчжүүлсэн тос хэрэглэсэн гэдгээ бүтээгдэхүүнийхээ шошгон дээр заавал бичих шаардлагатай юм байна. Хэрэв хүнсний бүтээгдэхүүний савлагааны шошгон дээр хатууруулсан, эсвэл устөрөгчжүүлсэн гэж бичсэн байвал транс тосны хольцтой гэсэн үг. Тухайлбал, дугуй шар, хуванцар савтай стандарт нэртэй маслоны шошгон дээр трансфат гэсэн бичиг байдгийг хүмүүс тэр бүр анзаардаггүй. Энэ нь устөрөгчжүүлсэн тосны найрлагатай илтгэж буй тайлбар юм. ДЭМБ-ын тогтоосон стандартаар хүн хоногт нэгээс илүүгүй хувийн транс тос хэрэглэвэл аюулгүй гэж үздэг. Нэг хувь гэдэг нь ойролцоогоор 2.5-3.0 грамм гэсэн үг.

Гэхдээ 2.5 грамм транс тосыг хүн биедээ шингээхэд зүрх судасны өвчтэй болох магадлал 23 хувиар нэмэгддэг байна. Транс тосны найрлагатай бүтээгдэхүүнийг байнга хэрэглэсэн тохиолдолд хүний

үүсээд зогсохгүй судас, бусад эрхтэнийг үрэвсүүлдэг.

Гэвч хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөгийг нь үйлдвэрлэгчид мэддэг хэрнээ бүтээгдэхүүнийхээ чанарыг алдагдуулахгүйн тулд транс тосны найрлагыг нэмсээр байдаг аж. Жишээлбэл, nestle, mars, сникерс зэрэг шоколад хүртэл энэхүү хортой тосны хольцтой байдгийг хойд хөршийн эмч нар анхааруулжээ.

Зуу гаруй жилийн өмнө химийн аргаар гаргаж авсан транс тос орчин цагт хүмүүсийн эрүүл мэндийн заналт дайсан болж хувирсан нь энэ. Учир нь анх 1897 онд ургамлын тосыг хатуу хэлбэрт оруулан устөрөгчжүүлэн транс тосыг гаргаж авсан нь тухайн үед эрдэмтдийн том ололт байв. Францын химич эрдэмтэн Поль Сабатье анх устөрөгчжүүлэх аргыг боловсруулсан бөгөөд энэхүү шинэ нээлтээрээ 1912 онд Нобелийн шагнал хүртэж байжээ.

Дэлхийн I дайны үед энэхүү тосны хэрэглээ улам нэмэгдэв. Байлдааны голомтын бүсэд хүнсний бүтээгдэхүүнийг муутгахгүйн тулд транс тос хэрэглэхээс өөр сонголт байсангүй. АНУ-д 25 жилийн өмнө транс тос хэрэглэн үйлдвэрлэж байсан торт өнөөг хүртэл өнгөө алдаагүй хадгалагдсаар иржээ. Транс тос бол бүтээгдэхүүний

хадгалах хугацааг хавьгүй уртасгаад зогсохгүй ихээхэн чанартай мэт харагдуулдагаараа онцлогтой.

Уг тосыг үйлдвэрлэсний дараа эмч нар хүний эрүүл мэндэд хамгийн аюулгүй гэж итгүүлдэг зогсохгүй, цөцгийн тосноос давуу чанартай хэмээн сурталчилдаг байв. Гэтэл цөцгийн тос болон амьтны гаралтай ханасан тосноос хэд дахин илүү хор хөнөөлийг эрүүл мэндэд учруулж буйг тухайн үед хэн ч таамагласангүй.

Хатууруулсан тос хүний эсийн бүрхүүлийг гэмтээдэг

Үүнээс хойш дэлхий дахинд транс тосны хэрэглээ хавтгайрчээ. Хяналтгүй хэрэглэсний уршгаар 30 гаруй мянган хүн эрүүл мэндээрээ хохироод зогсохгүй амиа алдсан гэж олон улсын судалгааны байгууллага онцолжээ. Энэ үеэс Дэлхийн эрүүл мэндийн байгууллага энэ аюулыг олон улсад байнга анхааруулдаг боллоо. Тус байгууллага 2020 он гэхэд дэлхийн улс орнуудын транс тосны хэрэглээг бүрмөсөн хориглохоор төлөвлөснөө ч

дуулгаад байгаа юм. Сүүлийн үед дэлхий дахинд зүрх судасны өвчлөл нэмэгдэж, нас баралтын шалтгаан болсны бурууг транс тостой ч холбох болов.

Дани улс транс тосыг хүнсний бүтээгдэхүүний найрлагад хэрэглэхийг хориглосны дараа зүрх судасны өвчлөл 30 гаруй хувиар буурсан байна. Тус улсад үр дүн ажиглагдсаны дараа Швейцарь хэрэглээг хязгаарлах шийдвэр гаргажээ. Ингээд зогсохгүй хэрэв транс тос хэрэглэсэн тохиолдолд тухайн бүтээгдэхүүний шошгон дээр заавал бичих ёстой гэсэн шаардлага тавьдаг болжээ. Канад мөн хэрэглээг хуулиар хязгаарлах хориг тавьжээ. Түүнчлэн АНУ бүх зоогийн газар, ресторанд хоолны орцон дахь транс тосны хэмжээг 0.5 граммаас хэтрүүлэхгүй байх шаардлага тавьж байна.

Харин манай улс өнгөрсөн жилээс л транс тосны аюулын талаар бага сага мэддэг болж эхлэв. Уг нь энэ талаар эрүүл мэндийн байгууллага иргэдэд эртнээс мэдээлэл өгч, дохио сэрэмжлүүлэг хүргэх ёстой байсан юм. Ийм байгууллага нь унтаа байдалтай байхаар иргэд эрүүл мэндийн мэдлэггүй, бас өвчлөл газар авч байна.

Дэлхийн улс орнуудаас Монгол транс тосны хор хөнөөлийн талаар нэлээд хожуу мэдэж авлаа. Энэ

тосны аюулыг мэдэхгүйгээс болоод талх, нарийн боовны бүх үйлдвэр өргөн хэрэглэдэг болсныг Мэргэжлийн хяналтын газрынхан хэлж байгаа. Ер нь олон улсын зах зээлээс шахагдсан транс тосыг бизнесмэнүүд хөгжиж буй хийгээд буурай хөгжилтэй орнууд руу цутгадаг юм байна. Гаалийн ерөнхий газрын импортын мэдээлэлд дурдсанаар өнгөрсөн жил маргарин агууламжтай тос 2749.6 тонныг оруулж иржээ. Маргарин агууламжтай тос импортлох эрхийг дөрвөн компанид олгосон байна. Түүнчлэн Малайз, Сингапур, Тайландаас транс тосны агууламж өндөртэй бүтээгдэхүүн оруулж ирдэг талаар МХЕГ-ын мэргэжилтнүүд онцлов. Гаалиар оруулж ирж буй маргарин болон устөрөгчийн агууламжтай тосноос таван хувийн татвар авдаг аж. Транс тосны татварыг гурав дахин нэмэх ёстой гэсэн байр суурийг өнгөрсөн зун Хүнс, хөдөө аж ахуйн яамныхан хэлж байсан ч эцсийн байдлаар шийдэгдээгүй байгаа юм билээ.

Судалгаагаар нийслэлд үйл ажиллагаа явуулдаг нарийн боовны үйлдвэрүүдээс 117 нь транс тос ихээр хэрэглэдэг нь тогтоогджээ. Эдгээр үйлдвэр түүхий эдээ ихэвчлэн ОХУ-аас оруулж ирдэг тухайгаа хүлээн зөвшөөрсөн байна. Хууль тогтоомжоор транс

Харин Хүнс, хөдөө аж ахуйн яамны Хүнсний үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Б.Даваадулам “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогод хүний эрүүл мэндэд хохирол учруулах, бусад улс орны хүнсний хэрэглээнээс хасагдаж байгаа бараа бүтээгдэхүүнийг Монгол Улсын хилээр оруулж ирэхийг хориглох тухай тусгасан.

Гэвч энэ заалтыг хэрэгжүүлэхэд цаг хугацаа шаардлагатай. Транс тосыг шууд хориглож болохгүй. Хөгжилтэй орнууд эхлээд хэрэглээг нь хязгаарлах арга хэмжээ авдаг. Монгол ч гэсэн тийм бодлогоор явах нь зөв байх. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль ч эрүүл мэндэд хохирол учруулах хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн тохиолдолд яах вэ гэдгийг тодорхой заасан байдаг” гэсэн тайлбар өглөө.

Монгол Улс одоогоор транс тосны хольцтой хүнсний бүтээгдэхүүнийг яах вэ гэдэг талаар тодорхой шийдвэр гаргаагүй байна. Хязгаарлагдмал зах зээлтэй улсад транс тосны хэрэглээг хязгаарлах амаргүй байх биз. Гэхдээ дэлхий нийтэд аюулыг нь тогтоогоод олон орон уг тосноос татгалзах арга хэмжээ авч байхад манай улс чимээгүй суугаад байж боломгүй юм. [ЗГМ]

С.ЦОГТБЯАР ЗУРЖ БАЙНА



Судлаачийн үг

Brexit-ийн түүхийг дуусгая-2



Brexit гамшиг дагуулсан юм биш байгаа

Олхонуд Баярхүү
Проф.

“Британийн ард түмний сонголтонд бид харамсаж байна. Европын Холбоо нэг гишүүнээ алдахын зэрэгцээ түүх, уламжлал, туршлагаасаа хэсгийг нь алдаж байна” хэмээн Европын Холбооны зургаан улсын Гадаад хэргийн Сайд нарын хамтарсан мэдэгдэлд тэмдэглэсэн нь нэг ёсны цөхрөлийн үг байсан юм.

2016 оны зургадугаар сард Британийн түүх орвонгоороо эргэх шиг болсон. Европын Холбоонд үлдэх, үлдэхгүй эсэх дээр хоёр талын тулаан ширүүн өрнөснийг түүх эргэлээ хэмээн нэрлэж буй хэргэ. Эрх баригч нэг намын эсрэг тэсрэг хоёр талын төлөөлөгчид болох Ерөнхий сайд Дэвид Кэмерон, Лондон хотын захирагч асан Борис Жонсон нар ширүүн үзэллэв.

Тэр хэрээрээ ч дараа нь хачирхалтай гэмээр мэдэгдлүүд хийцгээсэн. Гунигт автсан Кэмерон ингэж хэлж байв. Тэрбээр “Нэгдсэн Вант Улс маань Европын Холбоондоо байвал илүү хүчтэй, аюулгүй, илүү давуу талтай байх байсан ч Британийн иргэд маш тодорхой шийдвэр гаргаж тус улс цаашид өөр замаар замнахаар боллоо. Нөгөөтэйгүүр аравдугаар сар гэхэд Ерөнхий сайдын албан тушаалаасаа огцрох болно.

Шилжилтийн үед улс орны тогтвортой байдлыг хангах



BVM©

үүднээс Засгийн газар ирэх гурван сарын хугацаанд үргэлжлүүлэн ажиллана. Харин одоо Европын Холбоотой хийх хэлэлцэнд бэлтгэх хэрэгтэй боллоо. Шотланд, Уэльс, Умард Ирландын засаг захиргааг бүрэн оролцуулна. Нэгдсэн Вант Улсын өнцөг булан бүрийг хамгаална, хөгжих бололцоог нь хангана. Европын Холбоотой хийх албан ёсны хэлэлцээг миний дараагийн шинэ Ерөнхий сайд хийх болно” хэмээв.

Даан ч аравдугаар сарыг хүлээж чадалгүй тэр дороо огцорлоо. Европын Холбооноос гарах кампанит ажлын толгойлогч нь болж хувирсан Б.Жонсон улс орноо сүүлийн зургаан жилийн хугацаанд зоригтой сайн удирдсан Ерөнхий сайд Д.Кэмеронд талархал илэрхийлээд, улс орны өмнө тулгараад байсан хүндхэн асуудлыг зөв зүйтэй шийдвэрлэж өгсөн ард иргэддээ талархлаа гэж мэдэгджээ. Энэ шийдвэрийн дүнд бид өөрсдөө хуулиа тогтоож, бүрэн эрхт улс байх, хилээ хамгаалах, цагаачлалыг хязгаарлах зэрэг олон давуу талтай явлага хэмээн Тэрбээр сайрхаж байв. Европын Холбооны талд Шотландын Тэргүүн сайд Н.Стержин тууштай зогсон хилзгэнэж байсныг бид харсан. “Европын Холбооноос гарах нь буруу шийдвэр, алдаа. Санал асуулгын нэгдсэн дүн Шотландын ард иргэдийн хүсэл эрмэлзлэлийн эсрэг гарсан тул цаашид Шотланд нь Европын Холбоонд үлдэх чиглэлээр бүхий л шаардлагатай арга хэмжээ авна. Түүний дотор Шотландын тусгаар тогтнолын асуудлаарх санал асуулгыг дахин явуулах талаар ажиллана хэмээн заналхийлэхээ мартаагүй.

Судалгааны байгууллагууд ч

тооцоо судалгаа их хийгдсэн. “Digital Science” компанийн судалгаагаар Британи нь сүүлийн 10 жилийн хугацаанд эрдэм шинжилгээ, судалгааны ажилдаа Европын Холбооноос 8.04 тэрбум фунт стерлингийн санхүүжилт авсан ба санхүүжилт авсан хэмжээгээрээ Европтоо Германы дараа хоёрдугаарт бичигдсэн нь ашигтай ажилласныг нь илтгэх мэт. Их Британи нь шинжлэх ухааны судалгаанд ДНБ-ийхээ 1.63 хувийг зарцуулдаг бол Герман 2.84 хувийг зарцуулдаг, тиймээс Британийн эрдэм шинжилгээний байгууллагууд Европын Холбооны санхүүжилттээ ихээхэн хамааралтай гэсэн үг юм. Өөр нэг баримт байна. Европын Холбоо нь сүүлийн 10 жилийн хугацаанд хорт хавдрын судалгаанд зориулж Британид 126 сая фунт стерлинг, нанотехнологийн судалгаанд 13.5 сая фунт стерлинг тус тус олгож, мөн “Rolls-Royce” компанийн судалгааны үйл ажиллагааг 51 сая фунт стерлингээр, “BBC” компанийг 2.87 сая болон харилцаа холбооны “BT” компанийн судалгааны ажлыг 23.8 сая фунт стерлингээр тус тус санхүүжүүлжээ. Одоо энэ бүх санхүүжилт зогсоно, хохирогч нь Их Британи болж таарна.

Хэрэв Европын Холбооноос гарвал тус улсын эдийн засагт хэрхэн нөлөөлөх талаар хоёр дахь судалгааны дүнг Ерөнхий сайд Д.Кэмерон, Сангийн сайд Ж.Осборн нар тавдугаар сарын 23-нд танилцуулсан. Д.Кэмероны эцэслэн үр бүр ноцтой. Мөдхөн хийх гэж буй сонголт Британийн иргэн бүрийн амьдралд нөлөөлөх бөгөөд Европын Холбооноос гарвал “үнийн өсөлтийн их ангал руу эцэслэн орох”-той адил мэтээн тэрбээр зүйрлэв.

Судалгааны байгууллага	Европын Холбоонд үлдэх хүсэлтэй иргэд			Европын Холбооноос гаргах хүсэлтэй иргэд		
	2016.03.25	2016.04.07	2016.05.10	2016.03.25	2016.04.07	2016.05.10
Financial Times	45%	43%	46%	40%	41%	43%
Independent Communications and Marketing a Member of British Polling Council	41%	44%	44%	43%	43%	46%
Opinion Research Business	47%	51%	50%	49%	44%	50%

урьдчилсан тандалт судалгаагаар муу ёрыг их л зөгнөсөн дөө.

Financial Times-ийн судалгаанаас харахад хоёр сар орчмын хугацаанд Европын Холбооноос гарахыг дэмжигчдийн тоо гурван хувиар өссөн ч нийт санал асуулгад оролцогчдын дунд Европын Холбоонд үлдэхийг дэмжигчдийн тоо давамгайл байсан байна. Захирлуудын хүрээлэн (Institute of Directors) гэх ТББ-ын 1224 гишүүдийн 63 хувь нь Британийг Нэгдсэн Европт нь үлдэхийг дэмжсэн бол 29 хувь нь Европын Холбооноос гарахыг дэмжиж байв. Энэ тоо хоёрдугаар сард 60:31 хувийн харьцаатай байжээ.

Захирлуудын хүрээлэнгийн Ерөнхий захирал Саймон Уолкерийн хэлж байснаар бол, бизнес эрхлэгчдийн дийлэнх нь Европын Холбооны гишүүн орнуудтайгаа өргөн цар хүрээтэй хамтын ажиллагаа явуулдаг учраас Европын Холбооноос гарах нь Британийн эдийн засагт ихээхэн эрсдэлтэй, хохирол их учруулна хэмээн үзэж байв. Brexit-ийн эргэн тойронд элдэв

асуудлыг хөндөж ярьжээ. Юуны өмнө цагаачлалын асуудлаар Европын Холбооны хууль тогтоомжийг эргэн харна, Европын Холбооны шүүхийн оролцоог хязгаарлаж, Британийн хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж эхэлнэ, гэхдээ энэ нь хугацаа, чармайлт шаардсан чимхлүүр ажил болно. Харин Британи нь 2019 оныг дуустал Европын Холбоонд түншлэлийн нягт харилцаатай байлгахыг бид эрмэлзэнэ” гэжээ.

ХБНГУ-ын сөрөг хүчний жижиг намууд Brexit-ийн санал хуралтын дүнг ашиглан британичуудыг, Европын Холбооны хүнд суртлыг буруутгах, хашраах өнгө аясаар ярьж хэлж, баалж байв. Чөлөөт Ардчилсан Намын дарга П.Линднэр: Европын Холбооноос гарах Их Британид цаашдаа Холбооноос ямар нэгэн хөнгөлөлт үзүүлэхгүй байх ёстой. Зүүний Намын Бундестаг дахь намын бүлгийн дарга хатантай С.Вагэнкнхт “Брюссель дэх концернуудийн лобби ард иргэдийн итгэлийг хөсөрдүүлсний нотолгоо боллоо” гэв. Харин Германы төлөө Альтернатив намын Берлин мужийн дарга хатагтай Б.Шторх Brexit-ийг баяр хийж гэмдэглэнэ гэж байв.

Вреxit-ийг Скандинавын Нордик орнууд эмзэглэж, болгоомжлон хүлээн авсан. Шведийн Ерөнхий сайд Стифан Лавен “Их Британийн ард түмэн Европын Холбоог орхих шийдвэр гаргасан хэдий ч бид тэдний шийдвэрийг хүндэтгэнэ. Гэвч Европын Холбооны үлдсэн бусад улс орнуудад ямар хэмжээний хохирол амсах, яаж нөлөөлөх гэдэг л хамгийн чухал асуудал юм. Шведийн хувьд Британи нь худалдаа, эдийн засгийн хувьд хамгийн ойрхон, томоохон түншлэгч орны нэг, цаашид ч тийм байх болно. Иймд Шведийн Засгийн Газрын зүгээс авч хэрэгжүүлэх анхны алхам нь нийт Шведийн ард түмний ирээдүйн төлөө хийх хамгийн чухал хариуцлагатай алхам байх болно гэжээ. Тэр хариуцлагатай алхам гэдэг нь юу байж таарах вэ, Их Британийн санал асуулгын дүнд Швед, Дани хоёр улсын иргэдэд сөргөөр нөлөөлж, улмаар тэд Европын Холбооноос гарах асуудал яригдаж магад гэхэнэ.

Британийн Аж үйлдвэрийн холбооны судалгаагаар Нэгдсэн Вант Улсын эдийн засагт 100 тэрбум фунт стерлингийн буюу 138 тэрбум ам.долларын хохирол учирч, ойролцоогоор нэг сая ажлын байр үгүй болох тооцоог ОУВС-тай зэрэгцүүлэн хийж байв. Европын Зөвлөлийн дарга Д.Тускийн мэдэгдэл тэр дороо тархсан. Тэрбээр санал асуулгын дүнг бид арай өөрөөр төсөөлж байсан, энэхүү түүхэн санал асуулгын дүнгээс үүдэх улс төрийн болон бусад үр дагаврыг одоогоор тааж хэлэх боломжгүй байна гэжээ.

Европын Холбооны чирэгч гол мотор болох Германд Brexit-ийг хэрхэн хүлээн авсан нь эдийн засгийн түүх судлалд удтал яригдах сэдэв юм. Brexit ялсанд германы улс төр, бизнесийн хүрээнийхэн, олон нийт туйлын ихээр харамсжээ.

Гэхдээ Британийн ард түмний ардчилсан сонголт гэх манж үгээ дагалдуулахаа мартсангүй, нэгэнтээ л тийм юм бол хүлээн зөвшөөрөхөөс аргагүй.

Санал асуулгын ердөө маргааш нь Холбооны Канцлер хатагтай А.Меркелийн хийсэн мэдэгдэл байна. Тэрбээр “Brexit-ийн шийдвэрт их харамсаж байна. Европын Холбооны хөгжлийн замд өөрчлөлт гарсныг хүлээн зөвшөөрч, үр дагаврыг нь Европын Холбоонд эерэг байлгах талаар үлдсэн 27 гишүүн улс сайтар, нухацтай нягтлан судалж, нааштай шийдвэр гаргахаар хамтран ажиллана” гэв. Мөн Европын Холбооны бодлого, гол зорилгыг иргэдэд сайтар ойлгуулж ойртуулах хэрэгтэй. Олон сорилт бүхий өнөөгийн цагт Европын нэг орон дангаар дийлэхгүй учир Европын Холбооны хамтын хүчээр л сорилтуудыг давна. Европын Холбоог анх бий болгох үндсэн санаа нь Европт найрамдал, энх тайвныг бэхжүүлэх явдал байсныг хэзээ ч мартаж болохгүй. Европын Холбооноос гарах асуудлыг Гэрээнд зохицуулсны дагуу хэрэгжүүлнэ. Бүрэн гаргалаа Их Британи нь Европын Холбооны гишүүний эрхээ эдэлж, үүргээ биелүүлнэ. Цаашдын ирээдүйд ч Европын Холбоо болон Их Британийн хооронд түншлэлийн нягт харилцаатай байлгахыг бид эрмэлзэнэ” гэжээ.

ХБНГУ-ын сөрөг хүчний жижиг намууд Brexit-ийн санал хуралтын дүнг ашиглан британичуудыг, Европын Холбооны хүнд суртлыг буруутгах, хашраах өнгө аясаар ярьж хэлж, баалж байв. Чөлөөт Ардчилсан Намын дарга П.Линднэр: Европын Холбооноос гарах Их Британид цаашдаа Холбооноос ямар нэгэн хөнгөлөлт үзүүлэхгүй байх ёстой. Зүүний Намын Бундестаг дахь намын бүлгийн дарга хатантай С.Вагэнкнхт “Брюссель дэх концернуудийн лобби ард иргэдийн итгэлийг хөсөрдүүлсний нотолгоо боллоо” гэв. Харин Германы төлөө Альтернатив намын Берлин мужийн дарга хатагтай Б.Шторх Brexit-ийг баяр хийж гэмдэглэнэ гэж байв.

Вреxit-ийг Скандинавын Нордик орнууд эмзэглэж, болгоомжлон хүлээн авсан. Шведийн Ерөнхий сайд Стифан Лавен “Их Британийн ард түмэн Европын Холбоог орхих шийдвэр гаргасан хэдий ч бид тэдний шийдвэрийг хүндэтгэнэ. Гэвч Европын Холбооны үлдсэн бусад улс орнуудад ямар хэмжээний хохирол амсах, яаж нөлөөлөх гэдэг л хамгийн чухал асуудал юм. Шведийн хувьд Британи нь худалдаа, эдийн засгийн хувьд хамгийн ойрхон, томоохон түншлэгч орны нэг, цаашид ч тийм байх болно. Иймд Шведийн Засгийн Газрын зүгээс авч хэрэгжүүлэх анхны алхам нь нийт Шведийн ард түмний ирээдүйн төлөө хийх хамгийн чухал хариуцлагатай алхам байх болно гэжээ. Тэр хариуцлагатай алхам гэдэг нь юу байж таарах вэ, Их Британийн санал асуулгын дүнд Швед, Дани хоёр улсын иргэдэд сөргөөр нөлөөлж, улмаар тэд Европын Холбооноос гарах асуудал яригдаж магад гэхэнэ.

Норвегийн Ерөнхий сайд Эрна Солберг хэлэхдээ Их Британи Европын холбооноос гарч байгаа нь өнөөдөр бий болсон тулгамдсан асуудлуудыг шийдвэрлээгүйтэй шууд холбоотой өгч буй том сануулгын нэг боллоо. Энэхүү шийдвэрийн дүнд үүсэх зах зээлийн дам нөлөөлөөс урьдчилан сэргийлэх богино хугацааны төлөвлөгөө бидэнд бий. Ялангуяа олон улсын санхүүгийн байгууллагын санамжийг мөрдөн. Хөрөнгийн зах зээл, ханшийн өөрчлөлттэй холбоотойгоор үүсэх шууд бус үр дагаваруудад бэлэн байх нь чухал. Гэвч улс төрийн хувьд энэхүү шийдвэр үлэмж санаа зовоосон үйлдэл байж болох юм хэмээн онцлов.

Норвег нь Нэгдсэн Европт нэгдэхгүй бие даасан орон хэдий ч Шенгений бүсэд хамрагдаж, бүхий л худалдаа, хөрөнгө оруулалтын нөхцөлүүд нь Европын Холбооны стандарт, шаардлага, нөхцөлдүүдийн хүрээнд хийгддэг учраас үлэмж санаа зовсон нь тэр байв.

Финландын хувьд онцгой нөхцөл байдал үүссэн тул парламентын ээлжит бус чуулган яаралтай хуралдуулах, Финландын зүгээс умар арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар ойрын хугацаанд хэлэлцэх саналтай байгаагаа Ерөнхий сайд нь илэрхийлж байжээ.

Brexit дардан замдаа орлоо. Одоо ямар асуудал зовоох вэ гэдэгт европчууд бэлтгэж байх шув. Британи энэ холбооноос гарч дуусах хүртэл яриа хэлэлцээ хоёр жил үргэлжлэх нь байна. Яриа хэлэлцээнд хоёр гол асуудал бий. Нэгдүгээрт, Британиас Европг Холбоонд төлөх татвар хандивын асуудал, Европын Холбооны нутаг дэвсгэрт байгаа 1.2 сая британичууд, Британид байгаа Европын Холбооны гишүүн орны гурван сая иргэдийн цаашдын хувь заяа. Хоёрдугаарт, Британиас Европын Холбооны гишүүн орнуудтай хийх худалдааны асуудал голлож яригдана. Европын Зөвлөлийн даргын хэлж байгаа, энэ хоёр сэдвийн яриа хэлэлцээ ямар ч үр дүнгүйгээр 6-7 жил үргэлжлэх магадлалтай.

“Өөрөө ойлчсон хүүхэд үйлдэггүй” гэдэг шиг Британи нь Нэгдсэн Европоос хөндийрөх бэлтгэлээ өөрөө сайтар хийх шаардлагатай. Гэтэл Brexit-тэй зэрэгцээд фунт стерлингийн ханш огцом суларч, 1.3232 ам доллартай (дараа нь 1.3794 ам доллар болсон) тэнцэн 1985 оноос хойш анх удаа ханшийн ихээр унасан дүнтэй байж таарахгүй. Британийн төв банкны ерөнхийлөгч Марк Карни гэдгийг хэлснээр, цаашид санхүүгийн зах зээлээ тогтвортой байлгах шаардлагатай нэмэлт арга хэмжээнүүд авч таарна. Европын Холбооны бүтцэд өөрчлөлт орж байгаагаар холбогдуулан еврогийн ханшид бас нөлөөлсөн. Ханш нь 2.4 хувиар буурсан дүн зургадугаар сарын сүүдчээр харгдсан. “FTSE 100” индекс 4.7 хувиар буурч, Лондонгийн хөрөнгийн биржид бүртгэлтэй банк болон барилгын салбарын компаниудын хувьцааны ханш унаж тухайлбал, Barclays банкны хувьцаа 16 хувиар, орон сууцны Berkeley компанийн хувьцаа 21 хувиар унасан гэхчлэн ноцтой мэдээ нэг хэсэг салаагүй.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Манай компани нь дараах ажлуудыг гүйцэтгүүлнэ. Үүнд:

- Орхон аймаг Баян өндөр суманд баригдаж байгаа кино театрын барилгын лифт нийлүүлэх угсралтын ажил хийх
- Орхон аймаг Баян өндөр суманд баригдаж байгаа кино театрын дотор гадна металл болон бетон хийц дулааны сувагчлалын ажил
- Орхон аймаг Баян өндөр суманд баригдаж байгаа кино театрын шилэн фасад нийлүүлэх угсралтын ажил
- Орхон аймаг Баян өндөр суманд баригдаж байгаа кино театрын барилгын агааржуулалт хөргөлт, тоног төхөөрөмж, шугам хоолойн нийлүүлэлт угсралтын ажил
- Орхон аймаг Баян өндөр суманд баригдаж байгаа кино театрын барилгын гадна дотор бохир усны шугам угсралтын ажил
- Орхон аймаг Баян өндөр суманд баригдаж байгаа кино театрын цонхны хийц угсралтын ажил

Эрх бүхий аж ахуй нэгж, албан байгууллагууд хамтран ажиллахыг урьж байна.

Жич: Тендерийн материалыг 2016 оны 12 дүгээр сарын 1-ний өдрийн дотор ирж авна уу!

Тендерийн материалын үнэ: Тус бүр 30 000 төгрөг

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо Ерөнхий сайд Амарын гуламж, Соёлын төв Өргөө Б корпус Утас: 99056276 “НЬЮ ТУР САФАРИС” ХХК

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ
СОНИН АНХ

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шуудаг ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургалч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Тэргүүн орлогч эрхлэгч
Цэвээндолгорын ЦЭВЭЭНХЭРЛЭН
Утас: 99901526

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦИ

Улс төр, нийгмийн мэдээллийн алба
Эдитор Б.Гандолгор
Утас: 99901483

Эдийн засаг, бизнес мэдээллийн алба
Эдитор Р.Оюунцэцэг
Утас: 99901621

Гадаад контент, соёл энтертайментын алба
Эдитор Б.Энхжаргал
Утас: 99901682

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Г.Лхагвасүрэн
Утас: 99903581

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 хороо, Энхтайвны өргөн чөлөө, “Бло Скай тауэр” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар: 1024
Утас: 70103131,
Факс: 70106065

ЦАХИМ ХУВИЛБАР

Zasag.Co
“Чөлөөт хэвлэл”
сангийн хэвлэх үйлдвэрт хэвлэв

Дугаарын удирдагч
Л.Сугармаа

АВТО

АГУУ НЭЭЛТЭЭС ЭНГИЙН ХЭРЭГЛЭЭ ХҮРТЭЛ

О.Мишээл
ЗГМ

Эдүгээ энгийн хэрэглээнд тооцогддог автомашины зарим технологи анх хэрхэн бий болсныг сонирхуулъя.

ДОТООД ШАТАЛТЫН ХӨДӨЛГҮҮР

Германы инженер Николаус Отто 1878 онд анхны дөрвөн тактаат дотоод шаталтын хөдөлгүүрийг бүтээжээ. Харин хэрэглээнд өргөн нэвтэрсэн анхны хөдөлгүүрийг 1885 онд Карл Бенцийн бүтээсэн автомашинд ашигласан юм. Түүний "Моторваген" машин нэг морины хүч үл хүрэх чадалтай ганц цилиндрт хөдөлгүүртэй байв.

ИХ ГЭРЭЛ, ХӨДӨЛГҮҮРИЙН СТАРТЕР

Орчин цагийн машинд энгийн зүйл болсон их гэрэл, стартерийг 1912 оны Cadillac Model 30 Self Starter хэмээх машинд анх ашиглажээ. Гянт болд утас бүхий их гэрэл, хөдөлгүүр хялбар асаадаг технологи нь тухайн үедээ хувьсгал болсон байна. Чухам стартераас болж тухайн үед эхлэл төдий байсан цахилгаан хөдөлгүүрт машины хөгжил зогссон гэж үздэг.

ХУРДНЫ ХАЙРЦАГ

Францын инженер, Renault компанийн үндэслэгч Луи Рено 1898 оны арванхоёрдугаар сард Парисын огцом хэвгий бүхий



Рю Лепик гудамжийг өөрийн бүтээл Voiturette машинаар туулахаар шийджээ. Хурдны хайрцагныхаа ачаар Реногийн машин гудамжийг туулж чадсан тул франц инженер анх удаа 12 машины захиалга хүлээн авчээ.

ЭРГЭЛТ ЗААХ ДОХИОНЫ ГЭРЭЛ

Эхэн үеийн машинууд эргэх үедээ дэнлүү харуулдаг байснаа хожим нь сум хэлбэртэй заагч ашигладаг болжээ. Өдгөө бүгдийн танил болсон дохионы гэрлийн патентыг анх 1925 онд инженер Эдгар Вальтц авсан байна. Түүний патентын эрх 14 жилийн дараа дуусмагц уг технологи автомашинд өргөн нэвтэрчээ. Эргэлт заадаг дохион гэрэл бүхий

анхны машин нь 1939 оны Buick Roadmaster загвар байв.

ШИЛ АРЧИГЧ

Автомашины хөгжилд эмэгтэй хүн хувь нэмрээ оруулсан цөөн тохиолдлын нэг нь шил арчигч. АНУ-ын иргэн, Мэри Андерсон 1903 оны өвөл байнга машинаасаа гарч шилийг нь арчиж буй жолоочоо хараад механик хийцтэй арчигч бүтээх санаа төржээ. Тэрбээр уг санаагаараа патент эзэмшигч болсон юм. Хожим 1917 онд Шарлотта Брижвуд хэмээх өөр нэг эмэгтэй мөн л шил арчих механик хийцээр патент авсныг 1926 онд Bosch компани худалдан авчээ. Хэрэглээ сайтай уг санаа мөн ондоо дэлхийн олон үйлдвэрлэгчдийн

машинд өргөн нэвтэрчээ.

АЮУЛГҮЙН БҮС

Аюулгүйн бүс нь бүр өнгөрсөн зууны эхнээс техникт өргөн нэвтэрсэн ч автомашинд хэрэглэдэг тэрхүү "Гурван цэгийн бүс"-ийг Шведийн Volvo компани анх эсдэж олсон юм. Эдүгээ сая сая хүнийг ослоос эсэн мэнд аварч буй уг технологийг 1959 онд Volvo PV 544 машинд анх ашигласан байна. Үүнээс өмнө энгийн буюу хоёр цэгт бэхлэдэг бүс ашигладаг байсан нь аюулгүйн байдлын үзүүлэлтээр шведүүдийн бүтээлээс хол дутуу байжээ.

КОНДИЦИОНЕР

Кондиционер буюу сэрүүцүүлэх төхөөрөмжтэй машиныг

анх 1939 онд Чикагогийн автомашины үзэсгэлэнд сонирхуулжээ. Packard 12 хэмээх уг машинд нэмэлт сонголтоор суурилуулах үнэ тухайн үедээ 274 ам.доллар байсан нь шинэ машины үнийн гуравны нэгтэй тэнцэж байв. Кондиционероо ажиллуулах гэвэл жолооч хөдөлгүүрээ унтрааж, машины хамрыг сөхөн тусгай ременийг компрессорт нэмж угсардаг байв.

АЮУЛГҮЙН ДЭР

АНУ-ын зохион бүтээгч Аллен Брид 1967 онд автомашин саад мөргөхийг мэдэрдэг сенсер бүтээсэн нь аюулгүйн дэр үүсэх эхлэл болжээ. Аюулгүйн дэрийг 1971 онд Ford Taunus-т анх туршиж, жилийн дараа Oldmobile Toponado машинд нэвтрүүлэв. Гэхдээ уг технологи 1980-аад оны дунд үеэс л өргөн хэрэглээ болсон юм.

ЖОЛООНЫ ХҮРДНИЙ ГИДРО ӨСГӨГЧ

Өнгөрсөн зууны эхний 25 жилд машин жолоодох нь гарын булчин сайтай хүний ажил байв. Улмаар 1930-аад оноос анхны пневматик хийцтэй жолооны өсгөгч гарсан нь найдвар муутайгаас жолоочид түвэг учруулах нь илүүтэй байжээ. Хожим 1951 онд АНУ-ын Chrysler компани дээдсийн зориулалттай, ганган Crown Imperial хэмээх машиндаа анх гидро өсгөгч нэвтрүүлсэн. Европт гидрод өсгөгчийг 1954 онд Францын Citroen DS машинд анх ашиглажээ. [ЗГМ]

» ТАТВАР

БНХАУ "Ferrari", "Bentley Bentayga", "Aston Martin" зэрэг тансаг зэрэглэлийн автомашинуудад 10 хувийн татвар ногдуулж эхэллээ. Тансаг зэрэглэлийн машин утаа бага ялгаруулдаг гадна эрчим хүч бага зарцуулдаг учраас тохирсон хэмжээний татвар тогтоож байгааг онцолжээ.

» ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

"Apple" компани анх удаа автомат жолоодлоготой автомашины үйлдвэрлэлд хөрөнгө оруулах болсноо мэдэгдлээ. "Тээврийн салбарт автомат систем ашиглах боломжтой болж байгаадаа баяртай байна" хэмээн "Apple" компаниас мэдээлсэн байна.

» ОСОЛ

АНУ-ын Техас мужид цагдаагийн машин замын хажуугийн цооног руу унасан осол гарчээ. 3.6 метрийн гүнд машин унасны улмаас шериф Д.Нисихара амиа алдсан байна. Осол болсноос хойш нэг хоногийн дараа машины кранаар татаж гаргажээ.

Канадын Монреаль хотод их цас орж, зам дагтаршин мөстөний улмаас 10 гаруй машин хоорондоо мөргөлдсөн осол болжээ.

cardoctor.mn

ЗӨВЛӨГӨӨ

Халтиргаатай үед машинаа хэрхэн жолоодох вэ

Халтиргаатай замд машин жолоодох нь маш хэцүү. Ялангуяа өгсүүр, уруу зам, цасанд хучигдсан дов толгодыг давах нь бүр ч хүнд нөхцөл үүсгэдэг. Ийм бэрхшээлтэй тулгардаг жолооч нарт зориулж дараах зөвлөгөөг хүргэе.

ӨГСҮҮР ЗАМД

Дифференциал цоожлогч залгах: Гулгаатай өгсүүр замд дифференциал түгжигдсэнээр бүх дугуй тэнхлэг болон араатай холбогддог. Үүний үр дүнд өгсөх үед нэгэн зэрэг дэмжиж

өгөх юм.

Хаазыг жигд өг: Хаазыг аль болох бага, жигд гишгэх хэрэгтэй. Хэт их өгвөл дугуй хий эргэж, хүч алдах эрсдэлтэй.

Моторын эргэлтийг дундаж дээр нь барих: Үр дүнд нь дугуй хий эргэхгүй. Хэрэв хааз өндөр өгч, дугуйг огцом хүчтэй эргүүлвэл доороо хийж эргэж, гулгаан дээр хөдлөх боломжгүй болдог. Жигд хаазтай явах үеийн дугуй мөстэй гадаргуу дээр харьцахад хөдөлгүүрийн эргэлт ихэсдэг. Энэ үед дугуй мөсөн дээр хий эргэдэг тул хаазыг

тухайн үед хасаж өгөөрэй.

Бусдын гаргасан мөрөөр явахгүй байх: Гулгаатай өгсүүр замд бусад машины гаргасан мөрөөр явахгүй байх хэрэгтэй. Учир нь бусад машин замыг илүү гулгаатай, гялаан болгосон байдаг. Шинэ мөр гаргаж явах нь өгсөхөд илүү хялбар болгоно.

Баруун гар талдаа шахаж явах: Замынхаа баруун гарталыг барьж явбал дугуй зууралттай болно. Учир нь замын голын хэсэг илүү халтиргаатай байдаг. Энэ үед хашлага болон замын хажуугаасаа болгоомжилж

яваарай.

УРУУДАХ ҮЕД

Цаг агаарын хүнд нөхцөлд гулгаатай замаар уруудахад гол баримтлах зарчим нь алгуур, удаан явах юм. Ийм замд яг л уулын уруу алхаж буй мэт алгуур яваарай.

Тоормосыг бага багаар өг. Гар тоормосоо ашигла. Араг хүндрүүлж буу. Гэхдээ алгуур буугаарай. Ингэснээр болзошгүй эрсдэлээс сэргийлэх боломжтой. Хурдан явбал гулгаж, түүнийгээ засахын тулд жолоогоо огцом дарах, хэт хүчтэй тоормослох

зэргээр улам аюултай эрсдэлд орж болзошгүй.

Ачаа ихтэй эсвэл чиргүүлтэй явж байгаа үед биетүүд нэг чигт байгаа тохиолдолд л тоормосоо гишгээрэй. Үгүй бол машин хажуу тийш гулгах, чиргүүл хөндөлдөж унах аюулаас сэргийлэх юм.

Хэрэв механик хурдны хайрцагтай бол хүнд араанд байгаа чигээр нь тоормослоорой. Араа салгаатай үед дугуй хий эргэж, гулгадаг гэдгийг мартаж болохгүй.

Шилдгүүдийг нэг дороос...

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИНЫ
2017 ОНЫ I УЛИРЛЫН ЗАХИАЛГА ЭХЭЛЛЭЭ.
ЗАХИАЛГЫН ҮНЭ: 30,000₮



УЛИРАЛД

64 ДУГААР



Блю Скай тауэр, 4 Давхар, № 407, Энхтайваны өргөн чөлөө 17, 1-р хороо
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс, И-мэйл: info@zasag.co
Утас: +976 70103131, Факс: +976 70106065, Вэб: ubinfo.mn

Сурталчилгаа

ЭРХЭМ ЗАХИАЛАГЧ ТА “МОНГОЛ ШУУДАН” КОМПАНИД ХЭВЛЭЛЭЭ ЗАХИАЛНА УУ! 2017 ОНЫ I УЛИРЛЫН ХЭВЛЭЛ ЗАХИАЛГА СУМДАД 12-Р САРЫН 25-ИЙГ ХҮРТЭЛ, УЛААНБААТАР ХОТ БОЛОН АЙМГИЙН ТӨВҮҮДЭД 12-Р САРЫН 29-ИЙГ ХҮРТЭЛ ЯВАГДАНА

Хэвлэл захиалгын мөнгийг Улаанбаатар хотод “Монгол шуудан” Төрийн банкны 10000139702 тоот дансанд, бусад аймаг, хот, сум, суурин газруудад тус тусын банкны салбар дахь тухайн аймгийн шуудангийн газрын хэвлэлийн харилцах дансанд тушааж холбогдох тооцоог хийнэ.

“МОНГОЛ ШУУДАН” ТӨХК

УТАС/ФАКС: 70078916, 70078977, ШУУДАН ЛАВЛАХ: 1800-1613

ДАРААХЬ ХЭВЛЭЛЭЭДИЙГ РЕДАКЦИАС ГАРААГУЙ ТУЛ БУЦААН ТООЦОО ХИЙНЭ ҮҮ!

Д/д	ИНДЕКС	ХЭВЛЭЛИЙН НЭР	УЛИРАЛ
1	200534	Нээлттэй хичээл урлахуйн ухаан	2016.2-р улирал
2	206150	Тарлан тагзым	2016.2-р улирал
3	238007	Umbrella	2016.3-р улирал
4	254525	Хонгор зул	2016.2,3-р улирал
5	219665	Эрүүл мэндийн лавлах	2016.2-р улирал
6	200475	HUMAN CAPITAL	2016.3-р улирал

1. ӨДӨР ТУТМЫН СОНИН

Индекс	ХЭВЛЭЛИЙН НЭР	Улирал		Нэмэлт	
		Дугаар	Үнэ	Дугаар	Үнэ
102108	ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ +Financial Times	64	30000	44	21000
100943	АРДЧИЛАЛ	64	18000	44	16000
100774	ЗУУНЫ МЭДЭЭ /Уул уурхайн мэдээ+Бөхийн мэдээ сонинг үнэгүй дагалдуулна/	65	17500	43	12000
100757	МОНГОЛЫН МЭДЭЭ	64	18000	44	15400
100004	МОНГОЛЫН ҮНЭН	64	15000	42	10000
101545	ӨГЛӨӨНИЙ СОНИН	64	20000	45	17000
100816	ӨДРИЙН СОНИН	74-76	19600	52	13600
100518	ӨНӨӨДӨР + /Ням гариг амралтын дугаар/	75	20900	52	14500
105182	ӨНӨӨДӨР + UB POST	75+36	88800	52+26	56200
114876	УЛС ТӨРИЙН ТОЙМ	61	18000	45	15000
101361	ҮНДЭСНИЙ МЭДЭЭ	61	16000	45	11000
101606	ҮНДЭСНИЙ ШУУДАН /зууны шуудан/	64	19000	44	13000

2. ГУРАВ ХОНОГ ТУТМЫН СОНИН

Индекс	ХЭВЛЭЛИЙН НЭР	Улирал		Нэмэлт	
		Дугаар	Үнэ	Дугаар	Үнэ
100673	ШУУРХАЙ ЗАР /өдрийн шуудангаар хүргэгдэнэ/	24	36000	17	25500
100501	ЗАР МЭДЭЭ СУРТАЛЧИЛГАА /өдрийн шуудангаар хүргэгдэнэ/	23	34500	16	24000
100537	UB POST /Өнгөт, 12 нур, англи хэлээр/	36	68900	26	43700

3. ДОЛОО ХОНОГ ТУТМЫН СОНИН

Индекс	ХЭВЛЭЛИЙН НЭР	Улирал		Нэмэлт	
		Дугаар	Үнэ	Дугаар	Үнэ
100335	БИЗНЕС ТАЙМС	12	12000	8	8000
100029	ГАН ЗАМ	13	6900	9	4800
101587	ИРГЭНИЙ АРДЧИЛАЛ	12	7200	8	4800
101268	МОНГОЛ ЦУЦИН /Япон хэлээр/	13	12000	9	9000
100070	MONGOL MESSENGER /Англи хэлээр/	13	12000	9	9000
100702	МОНГОЛЫН МЭДЭЭ /Хятад хэлээр/	13	12000	9	9000
100184	НОВОСТИ МОНГОЛИИ /Орос хэлээр/	13	12000	9	9000
101119	OPEN DOOR /НЭЭЛТТЭЙ ХААЛГА/	12	13000	8	9000
101570	ӨНӨӨДРИЙН ТОЙМ	12	6000	8	4000
100018	СОЕМБО	13	5000	9	3000
100459	СЭРҮҮЛЭГ	12	6000	8	5000
101688	УЛААНБААТАРЫН СОНИН	12	11000	8	7200
100011	ХӨДӨЛМӨР	12	6600	8	4400
100178	ХҮМҮҮН БИЧИГ	12	3000	8	2000

4. АРАВ ХОНОГ ТУТМЫН СОНИН

Индекс	ХЭВЛЭЛИЙН НЭР	Улирал		Нэмэлт	
		Дугаар	Үнэ	Дугаар	Үнэ
100752	БОЛСОН ЯВДАЛ	9	13500	6	9000
100161	БӨХ	9	7200	6	4800
101175	МОНГОЛЧУУДЫН АМЬДРАЛ	9	6000	6	4600
100013	МОНГОЛЫН ХӨДӨӨ	6	6000	4	4000
100645	НОЦТОЙ МЭДЭЭ	9	13500	6	9000
101478	ОДОО ЦАГ	6	6600	3	3300
100912	САНХҮҮГИЙН МЭДЭЭ	9	5400	6	3600
100012	УТГА ЗОХИОЛ, УРЛАГ	9	5000	6	4000
100474	УГИЙН СУЛЖЭЭ	10	6000	6	3600
159918	ХОРИОТТОЙ БҮС	7	7700	4	4400
100229	ХӨХ ТОЛВО	9	4500	6	3000
101665	ЭХ ОРНЫ МАНАА	9	5000	6	3500

5. АРВАН ДӨРӨВ ХОНОГ ТУТМЫН СОНИН

Индекс	ХЭВЛЭЛИЙН НЭР	Улирал		Нэмэлт	
		Дугаар	Үнэ	Дугаар	Үнэ
100164	АМЬДРАХ УХААН	6	4800	4	3200
100624	АНАГААХ АРГА БИЛИГ	6	9600	4	6400
100625	АНАГААХ АРГА БИЛИГ /2015 ОНЫ ХУУЧИН ДУГААРУУД БАГЦ/	1	28800	1	28800
101560	ДАЛД АМЬДРАЛ	6	8000	4	5400
100001	МЭРГЭШСЭН НЯГТЛАН БОДОГЧ	6	5400	4	3600
109110	ОНЦГОЙ МЭДЭЭ	6	4500	4	3000
100064	САНХҮҮ БАНКНЫ МЭДЭЭЛЭЛ	6	6000	4	4000
163451	ЭРҮҮЛ МЭНДИЙН ЖОР	5	7500	3	4500

6. САР ТУТМЫН СОНИН

Индекс	ХЭВЛЭЛИЙН НЭР	Улирал		Нэмэлт	
		Дугаар	Үнэ	Дугаар	Үнэ
101058	АЛТАН ЧАГНУУР	3	3000	2	2000
101081	БАГШ	3	6000	2	4000
100548	БИЛГИЙН МЭЛМИЙ	3	1500	2	1000
115457	ГЕОЛОГИ УУЛ УУРХАЙН МЭДЭЭ	3	3000	2	2000
101057	ГЭР ГЭРТЭЭ ТОГОСЧ	3	5400	2	3600
100520	ДАЛ /Зөвлөлт сонин, Өнгөрсөн, одоо, ирээдүйн зөн сонин, танин мэдэхүйн/	3	3000	2	2000
107990	Ерөнхий эрдмийн хичээлүүд англи-монгол хэл дээр №1 А.Дүрэм Б. Унших дасгал /Ангели хэл сурх үндэсний шилдэг технологи/	1	5000	1	5000
100021	МОНГОЛЖИНГОО	3	1350	2	900
107660	Математик 1-3 анги	3	6000	2	4000
107661	Математик 4-5 анги	3	6000	2	4000
107662	Математик 6-9 анги	3	6000	2	4000
107663	Математик 10-12 анги	3	6000	2	4000
100873	НЭЭЛТТЭЙ СУРГУУЛЬ	3	1800	2	1200
101001	ОЮУНД ТУССАН ГЭГЭЭ	3	3000	2	2000
100620	ХАНЬ	4	5200	3	3900
101409	ХӨДӨӨ АЖ АХУЙН МАРГААШ	3	1500	2	1000
101016	СЭТГЭЛ ЗҮЙЧ	2	5400	2	5400
100651	ЦОХ /хүүхдийн танин мэдэхүйн сонин-бүх нур өнгөтөөр/	3	5000	2	3400
100813	ЭИМЧ	3	3000	2	2000
101539	Сурагчийн ертөнц	3	4500	2	3000
101655	Шамбалын гэрэл /2009 оны 12 дугаар/	1	15000	1	15000
1102701	"Математикийн цаг" I анги /Захиалагчид "Өөрийн үнэлгээ 1-р анги" I ба II дэвтэр бэлэглэнэ/	Үндсэн 3 хавсралт 1	5900		
1102702	"Математикийн цаг" II анги /Захиалагчид "Өөрийн үнэлгээ 2-р анги" I ба II дэвтэр бэлэглэнэ/	Үндсэн 3 хавсралт 1	5900		
1102703	"Математикийн цаг" III анги /Захиалагчид "Өөрийн үнэлгээ 3-р анги" I ба II дэвтэр бэлэглэнэ/	Үндсэн 3 хавсралт 1	5900		
1102704	"Математикийн цаг" IV анги /Захиалагчид "Өөрийн үнэлгээ 4-р анги" I ба II дэвтэр бэлэглэнэ/	Үндсэн 3 хавсралт 1	5900		
1102705	"Математикийн цаг" V анги /Захиалагчид "Өөрийн үнэлгээ 5-р анги" I ба II дэвтэр бэлэглэнэ/	Үндсэн 3 хавсралт 1	5900		
1102706	"Математикийн цаг" VI анги /Захиалагчид "Өөрийн үнэлгээ 6-р анги" I ба II дэвтэр бэлэглэнэ/	Үндсэн 3 хавсралт 1	5900		
1102707	"Математикийн цаг" VII анги /Захиалагчид "Өөрийн үнэлгээ 7-р анги" I ба II дэвтэр бэлэглэнэ/	Үндсэн 3 хавсралт 1	5900		
1102708	"Математикийн цаг" VIII анги /Захиалагчид "Өөрийн үнэлгээ 8-р анги" I ба II дэвтэр бэлэглэнэ/	Үндсэн 3 хавсралт 1	5900		
1102709	"Математикийн цаг" IX анги /Захиалагчид "Өөрийн үнэлгээ 9-р анги" I ба II дэвтэр бэлэглэнэ/	Үндсэн 3 хавсралт 1	5900		
1102710	"Математикийн цаг" X анги /Захиалагчид "Өөрийн үнэлгээ 10-р анги" I ба II дэвтэр бэлэглэнэ/	Үндсэн 3 хавсралт 1	5900		
1102711	"Математикийн цаг" XI анги /Захиалагчид "Өөрийн үнэлгээ 11-р анги" I ба II дэвтэр бэлэглэнэ/	Үндсэн 3 хавсралт 1	5900		
1102712	"Математикийн цаг" XII анги /Захиалагчид "Өөрийн үнэлгээ 12-р анги" I ба II дэвтэр бэлэглэнэ/	Үндсэн 3 хавсралт 1	5900		
1102714	Математикийн ажлын дэвтэр 2-р анги	1	3600		
1102715	Математикийн ажлын дэвтэр 3-р анги	1	3600		
1102716	Математикийн ажлын дэвтэр 4-р анги	1	3600		
1102717	Математикийн ажлын дэвтэр 5-р анги	1	3600		
1102718	Математикийн ажлын дэвтэр 6-р анги	1	3600		
1102719	Математикийн ажлын дэвтэр 7-р анги	1	3600		
1102720	Математикийн ажлын дэвтэр 8-р анги	1	3600		
1102721	Математикийн ажлын дэвтэр 9-р анги	1	3600		
1102722	Математикийн ажлын дэвтэр 10-р анги	1	3600		
1102723	Математикийн ажлын дэвтэр 11-р анги	1	3600		
1102724	Математикийн ажлын дэвтэр 12-р анги	1	3600		

7. ОРОН НУТГИЙН ХЭВЛЭЛ

Индекс	ХЭВЛЭЛИЙН НЭР	Улирал		Нэмэлт	
		Дугаар	Үнэ	Дугаар	Үнэ
125312	АРХАНГАЙН ТОЛЬ	12	5500	8	4000
101111	ГОВИЙН ӨНГӨ ТӨРХ	12	5000	8	4000
163338	ДОРНОГОВИЙН ШУУДАН	6	3000	4	2000
154053	ДӨЛ /Дөрвөлж	6	3000	4	2000
101180	ДАЛАЙ ЭЭЖ	9	7200	6	4800
131363	МОНГОЛ ЗАМАН	6	4500	4	3000
190709	НАР ТУССАН ЦАГ /Эрдэнэт/	24	10000	16	8000
204584	ЭРДЭНСЭЙН ГЯЛБАА /Эрдэнэт/	3	8000	2	6000
101666	ӨНӨӨГИЙН БАЯНХОНГОР	9	4500	6	3000
104085	ӨНӨӨГИЙН ЭРДЭНЭТ	12	4000	8	2700
106003	ӨНӨӨДРИЙН ЯЛАЛТ	6	4200	4	2800
201009	СОНИРХОЛТОЙ ДЭЛХИЙ /Сэтгүүл/	3	12000	4	8000
101642	ТАНЫ ЭЛЧ /Өвөрхангай/	12	6000	8	4000
101607	ХОВДЫН ТОЛЬ+Бизнес толь+Ирээдүйн толь	12	6000	8	4000
193342	Хотын шуудан /Эрдэнэт/	12	8000	8	6500
101285	ШИНЭ ЗУУНЫ ХЭНТИЙ	6	3600	4	2400
100976	СУХБААТАР ТАЙМС	9	4500	4	2000
104362	ЭРДЭНЭТ ХӨГЖИЛ /Сэтгүүл/	1	3000	1	3000
101056	ЭРДЭНЭТ ТАЙМС	9	3850	6	2800
100746	ЭРХ ЧӨЛӨӨ /Хөвсгөл/	12	6000	8	4000
201045	ӨВӨРХАНГАЙН ӨНГӨ /Сэтгүүл/	3	10000	2	7000
201005	НУТГИЙН СОЕМБО СЭТГҮҮЛ	3	12000	2	8000

1. АНАГААХ УХААН, ЭРҮҮЛ МЭНД

Индекс	ХЭВЛЭЛИЙН НЭР	Улирал		Нэмэлт	
		Дугаар	Үнэ	Дугаар	Үнэ
200443	INNOVATION/Шинэ санаа, Шинэ нээлт	1	9600	1	9600
200027	МОНГОЛЫН АНАГААХ УХААН	1	5000	1	5000
203171	МОНГОЛЫН МАЛ ЭМНЭЛЭГ	2	9000	2	9000
200175	ОНОШ	1	5000	1	5000
210083	ЭРҮҮЛ АМЬДРАХ ЖОР	3	9000	2	6000
200449	ЭРҮҮЛ МЭНД ИНЭМЭСЭГЛЭЛ	1	6000	1	6000
219665	ЭРҮҮЛ МЭНДИЙН ЛАВЛАХ				

Альцгеймерийг эмчлэх шинэ найдвар

Массачусетсийн технологийн их сургууль анивчсан гэрлээр Альцгеймерийн өвчнийг эмчлэх боломжийг судалжээ. > 10

Хятадууд Малайзын өрийг дарахад тусална

Санхүүгийн бэрхшээлд орсон Малайзын 1MDB хэмээх улсын хөрөнгө оруулалтын санд Хятад улс туслахыг зөвшөөрөв. > 10

Туркийн арми дахь цэвэрлэгээ НАТО-г сулруулсан

Офицеруудийг халсан нь Туркийн армийн өөрийнх нь цэргийн чадамжид муугаар нөлөөлнө гэсэн байна. > 10

Филиппин батлан хамгаалах чадвараа бэхжүүлэхэд анхаарч байна

Майкл Пил, Виктор Маллет

Дэлхийн худалдаанд голлох үүрэгтэй бүс нутгийн их гүрнүүдийн өрсөлдөөнөөс үүдэн аюулгүй байдлын үзэл баримтлал хувирч буй. Ийм үед Филиппин зэвсэглэлээ нэмэгдүүлж, бүс нутгийн хөршүүдтэйгээ батлан хамгаалах хэлхээ холбоогоо бэхжүүлж эхлэв.

Манила батлан хамгаалах салбарт АНУ-аас хамааралтай байдлаа багасгахыг эрмэлзэж байгаа. Нөгөө талаар Ерөнхийлөгч Родриго Дутерте Бээжинд айлчилсан ч Филиппин нь БНХАУ-ын дагуул улс болохгүй гэдгийг Филиппиний Батлан хамгаалахын сайд Дельфин Лоренцана мэдэгдлээ. “Бид Индонезоос хөлөг онгоц, Солонгосоос нисэх онгоц болон усан онгоц худалдан авч байгаа. Япон ч цэргийн зориулалттай хөлөг нийлүүлдсэн” хэмээн ноён Лоренцана тайлбарлав. Сайдын өрөөнд хэдийнэ тус улсад нийлүүлж эхэлсэн Солонгосын FA-50 сөнөөгчийн том загвар тавиастанд байлаа.

“Бид АНУ-тай харилцаагаа хэвээр үргэлжлүүлнэ. АСЕАН-ын хөршүүдтэйгээ ч батлан хамгаалах салбарт хамтран ажиллана” хэмээн тэрбээр Financial Times-д өгсөн ярилцлагадаа өгүүлэв. БНХАУ оролцсон нутаг дэвсгэрийн маргаан, Дональд Трамп АНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдсоноос шалтгаалан Филиппин батлан хамгаалах салбартаа анхаарах шаардлагатай боллоо. Ноён Дутерте Филиппиний “Хэт сул” батлан хамгаалах салбарыг үлэмжхэн сайжруулах зорилго тавьж байгааг сайд тайлбарлав.



BBM©

Филиппиний зэвсэгт хүчийг шинэчлэн сайжруулах ажлын хоёрдугаар шат буюу ирэх таван жилд батлан хамгаалах салбарт 2.3 тэрбум ам.доллар зарцуулах саналыг тус улсын Конгресс сайшаана хэмээн найдаж байгаагаа сайд өгүүллээ.

Манила нь тэнгисийн цэрэг, агаарын цэргийн хүч, эргийн харуулын албанд зориулсан зэвсэг техникийг Бээжингээс хүртэл худалдан авсан. “Хэрэгтэй бол Хятадаас авахад болохгүй нь юу байна?” хэмээн ноён Дутерте Бээжинд айлчлах үедээ асуулт тавьж байсан юм.

Филиппин нь Хятадтай нутаг дэвсгэрийн маргаантай Вьетнам, Индонез, Малайз зэрэг Зүүн өмнөд Азийн бусад томхон хөрштэйгээ ч батлан

хамгаалах хамтын ажиллагаагаа өргөжүүлэх эрмэлзэлтэй. Манила нь 1990-ээд оны эхээр Вашингтонд шахалт үзүүлж цэргийн баазыг нь Филиппинээс гаргаснаас хойш үүссэн орон зайг орлох холбоотон хайж байна. Тэр цагаас хойш “Батлан хамгаалах салбар ганц улсаас хамааралтай байх нь муу гэсэн ойлголт ихэссэн” талаар сайд ярилаа.

Гэхдээ “Бид АНУ-аас харилцаагаа бүрмөсөн таслахгүй. Хоёр улсын ард түмний харилцаа одоо ч бат бэх. Манайд АНУ-ын 100 мянган иргэн амьдардаг бол нэгдсэн улс гурван сая филиппин гаралтай иргэнтэй” хэмээн ноён Лоренцана тайлбарласан юм. Урьд нь армийн хошууч генерал байсан ноён Лоренцана

Вашингтон дахь Филиппиний Элчин сайдын яаманд арав гаруй жил ажилласан хүн. Түүний гурван хүүхэд эдүгээ АНУ-д амьдардаг.

Ноён Лоренцана болон Филиппиний бусад сайд Родриго Дутерте зургадугаар сард Ерөнхийлөгч болсноос хойш гадаад болгогд гарсан өөрчлөлтөд зохицохоор чармайж байна. Филиппиний Ерөнхийлөгч Хятадтай нутаг дэвсгэрийн маргаантай арал дээр эх орныхоо тугийг мандуулахаар моторт завиар очих тухай мэдэгдэж байсан удаатай. Гэвч тэрбээр долдугаар сард нутаг дэвсгэрийн маргааныг Манилын талд ашигтай шийдсэн олон улсын шүүхийн шийдвэрийг үл хэрэгсэв. Филиппиний удирдагч

аравдугаар сард Хятадад айлчлахдаа уг шийдвэрийг “Хуудас цааснаас цаашгүй эд” хэмээн үнэлээд Манила Вашингтоноос “Тусгаарлаж байгаа”-г зарласан.

Уг хэргийн дараа Хятадын эрх баригчид хоёр улсын хооронд 2012 оноос хойш хэрүүлийн үндэс болж ирсэн Скарборо арлын орчимд загас авлахыг Филиппиний загасчдад зөвшөөрлөө. Гэхдээ маргаантай нутаг дэвсгэрийн асуудлаар Филиппин хатуу байр суурь баримталсан хэвээр байгааг ноён Лоренцана анхааруулав. Тэрбээр Хятад улсыг холбоотон гэхээсээ анд нөхөр хэмээн тодорхойлох нь зүйд нийцнэ хэмээн тайлбарласан юм. Мөн Манилаас Бээжинтэй хийж буй тохиролцоог бүс нутгийн хөршүүд нь анхааралтай ажиглаж, анхааруулга өгч буй талаар далимд нь дурдлаа.

“Бид эрхээ хамгаалах ёстой ч батлан хамгаалах чадвар сул байгаа үед бодолцох юм бий. Одоохондоо Хятадын эргийн харуулын онгоцыг сөрөн зогсож дийлэхүйц томхон хөлөг ч бидэнд алга” хэмээн сайд өгүүлэв.

АНУ-Филиппиний харилцаа цаашид ч хэвээр үргэлжилнэ гэдгийг ноён Лоренцана цохон тэмдэглэсэн. Түүний ажлын өрөөнд Дэлхийн II дайны үед япончуудын булган эзлэлтийн улмаас шахагдан гарсан АНУ-ын колонийн засаг захиргааны тэргүүн, генерал Дуглас Макартур Филиппинд эргэн ирж буй зураг өлгөөтэй байлаа.

Манила АНУ-аас зай барьж эхэлсэнд Вашингтоны ойрын холбоотон Япон, Өмнөд Со-

лонгос түгшиж байгааг ноён Лоренцана хүлээн зөвшөөрөв. АНУ нь Ойрх дорнод, Украины асуудалд анхаарсаар Зүүн өмнөд Азийн аюулгүй байдлыг орхигдуулж, Хятадад “Арал булаах” боломж олгосон хэмээн сайд Вашингтоныг буруутгав.

Гэхдээ Филиппин нь 1951 онд Вашингтонтой байгуулсан аюулгүйн гэрээгээ хэвээр мөрдөх хүсэлтэйг ноён Лоренцана онцлон анхааруулаа. АНУ нь уг гэрээний дагуу тус улсад цэргийн зэвсэг техник хадгалах, исламын радикал бүлэглэлүүд идэвхтэй ажилладаг өмнөд Филиппиний арлуудад цэрэг байрлуулах эрхтэй. Филиппин нь цаашид ч цэргийн хамтарсан сургуулилтгыг, ялангуяа гамшгийн хохирлыг арилгах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх чиглэлээр үргэлжлүүлэх эрмэлзэлтэй байгааг сайд нэмж дурдлаа.

Дональд Трамп өнгөрсөн сард Ерөнхийлөгчийн сонгуульд ялснаас хойш ноён Дутертегийн АНУ-д хүйтэн хандаг явдал багаснаас сайд мөн анхааруулав. Ноён Трамп Филиппиний Ерөнхийлөгчийг ирэх жил Цагаан ордонд айлчлаашид ч хэвээр үргэлжилнэ гэдгийг ноён Лоренцана цохон тэмдэглэсэн. Түүний ажлын өрөөнд Дэлхийн II дайны үед япончуудын булган эзлэлтийн улмаас шахагдан гарсан АНУ-ын колонийн засаг захиргааны тэргүүн, генерал Дуглас Макартур Филиппинд эргэн ирж буй зураг өлгөөтэй байлаа.

Манила АНУ-аас зай барьж эхэлсэнд Вашингтоны ойрын холбоотон Япон, Өмнөд Со-

Айовагийн захирагч Хятадад АНУ-ыг төлөөлнө

Барни Жопсон, Жефф Дайер

Дональд Трамп Айова муж улсын захирагч Терри Бранстедийг БНХАУ-д суух Элчин сайдаар сонголоо. Ийнхүү дипломат ажлын дадлага туршлага бага ч хашир улстөрч АНУ, БНХАУ-ын харилцааны төвд орж ирлээ. Сенатаас батлах ёстой шинэ Элчин сайд Бранстед нь АНУ-ын шинэ засаг захиргааны бодлогыг Бээжинд илүү хатуу гараар хэрэгжүүлэх хүн хэмээн зарим нь таамаглаж байна. Гэтэл ноён Трамп, Тайванийн Ерөнхийлөгч хоёрын утсаар ярилцсан ярианаас болж хоёр улсын харилцаанд хэдийнэ шуугиан дэгдээд амжсан.



хүсэж байна” хэмээн хэвлэлийн хурал дээр төлөөлөгч мэдэгдлээ.

Ши Жиньпин бага тушаалын албан хаагч байсан 1985 онд Айова мужид зочилсноо байнга дурсдаг. Хожим нь БНХАУ-ын удирдагч болохоосоо өсөн сарын өмнө буюу 2012 оны хоёрдугаар сард тэрбээр дахин тус муж улсад айлчилсан юм. Айлчлалын үеэр түүнийг “Хуучин цагийн анд” Бранстед хүлээн авч зочилжээ.

Сонгуулийн кампанийнхаа үеэр Хятадын эдийн засгийн бодлогыг ширүүн шүүмжилж байсан ноён Трамп өнгөрсөн долоо хоногт Тайванийн Ерөнхийлөгчтэй утсаар ярилцаж АНУ, Хятадын харилцааг доргиогоод авсан. АНУ, Тайванийн удирдагчдын хооронд 1979 оноос хойш ийм холбоо үүсэж байгаагүй билээ.

Айова муж улсын Дрэйкийн их сургуулийн улс төрийн ухааны эрдэмтэн, Хятад судлаач Дэвид Скидмор “Уг томилгоо нь Трампд Хятадын удирдлагуудтай

танил, хувийн хэлхээ холбоо сайтай хүн хэрэгтэй байгааг харууллаа” хэмээн тайлбарлав. Терри Бранстедийн хүү Эрик нь Айова муж улсад ноён Трампын сонгуулийн кампанийн менежерээр ажилласан. Трамп ч арваннэгдүгээр сарын сонгуулиар тус муж улсад баттай ялалт байгуулжээ.

“Энэ томилгоо Трампаас Бранстедийнхэнд өгч буй бэлэг боллоо. Мөн Трамптай улс төрийн ойр харилцаа бүхий хүн Элчин сайд болсныг Хятадын удирдлагад ойлгууллаа” хэмээн ноён Скидмор өгүүлж байна. Терри Бранстед шинэ албан тушаалд тохирохуйц худалдаа, хөдөө аж ахуйн мэдлэг туршлагатайг Трампын төлөөлөгчөөс сэтгүүлчдэд тайлбарлав. “Бранстед нь Хятад улс, Хятадын ард түмний талаар асар их мэдлэгтэй. Сонгуулийн кампанийн үеэр төдийгүй, сонгуулийн дараа ч Ерөнхийлөгчөөр сонгогдогчтой уулзахдаа гүн сэтгэгдэл төрүүлж чадсан хүн” хэмээн ноён Скидмор ярилаа.

Трамп Хятадын эсрэг уур амьсгал шингэсэн мэдэгдлээрээ зартай ч “Байдлыг хөнгөргөж орхих хүн биш” хэмээн ноён Скидмор үзлээ. “Бас ч гэж прагматик. Бүгд найрамдах намын бүтцийн ангиллаар бол энэ хүн залуу цагийнхаасаа хавьгүй баруун талдаа байр суурь баримтлагч. Нийт намынхан дотроо авч үзэх юм бол аялуу үзэлтэй ч гэж болно” хэмээн нэмж хэллээ.



Хүүхдэд халтай хүнсний сурталчилгааг хориглов

Шехеразаде Данешку

Их Британийн сурталчилгааны шинэ журмын дагуу хүүхдийн зүүн мэдлэг халтай хүнсний бүтээгдэхүүнийг твиттер, фэйсбүүкээр сурталчлахыг хориглов. Шинэ журам нь телевиз, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, кино, хэвлэмэл бүтээгдэхүүнийг хамарч байна.

HFSS буюу өөх тос, чихэр, давс ихтэй хүнсний бүтээгдэхүүнийг 16-гаас доош насныханд сурталчлахыг хориглосон хоригийг ирэх долдугаар сараас хүчин төгөлдөр мөрдөж эхлэх талаар тус улсын зохицуулах байгууллага Сурталчилгааны практикийн комисс (CAP) пүрвэ гаргагт мэдэгдлээ.

“Энэхүү хориг нь хүүхдүүдийн нүдэнд өртөж буй тос, чихэр, давсны орц ихтэй хүнс, ундааг үлэмж хэмжээгээр цөөрөхөд хүргэнэ” хэмээн тус комисс тайлбарлав. Хүүхдийн таргалалтын шалтгаан болж буй чихэрлэг ундаанд татвар оногдуулах хуулийн төслийг Засгийн газар сайшааснаас хойш хэдхэн хоногийн дараа уг журам гарлаа. Эдүгээ Их Британийн залуу үеийнхний гуравны нэг нь жин хэтэрсэн юм уу, таргалалттай.

Стратеги нь энэ зун тодорхой болсон, хүүхдийн таргалалтыг багасгах талаар Засгийн газраас хэрэгжүүлэх төлөвлөгөөг эрүүл мэндийн кампани өрнүүлэгчид шүүмжилдэг. Хүүхэд, залуу үеийнхний үзэх дуртай X Factor шоу зэрэг телевизийн

нэвтрүүлгийн үеэр эрүүл мэндэд таагүй хүнсний бүтээгдэхүүн сурталчилж байгаад хязгаарлалт тогтоохыг тус улсын иргэд шаардсаар өдий хүрлээ.

Өөх тос, чихэр ихтэй бүтээгдэхүүний сурталчилгааг ихэнх хүүхдэд орондоо ордог оройн 21.00 цагаас өмнө нэвтрүүлэхийг хориглох уриалгыг Cancer Research UK байгууллага гаргаад байна. Тус улсын нийт телевиз үзэгчдийн 25 хувь хэмээн тооцоолж буй хүүхдүүдэд тусгайлан зориулсан сурталчилгааг хориглож буй журамд дээрх шаардлагыг хараахан тусгасангүй.

Шинэ журам нь хүүхдүүдийн ашигладаг мэдээллийн хэрэгсэл өөрчлөгдөж буй чиг хандлагыг харгалзаж үзсэн талаар CAP тайлбарлав. Их Британийн 5-15 насны хүүхдүүд долоо хоногт дунджаар 15 цагийг онлайнд өнгөрөөдөг. Энэ нь телевиз үздэг цагаас нь их байгааг Ofcom зохицуулах байгууллага тооцоолжээ. Тус улсад телевизийн сурталчилгаанд хязгаарлалт тогтоох журам 2007 оноос хэрэгжиж эхэлсэн юм.

“Эрүүл бус хүнсний онлайн сурталчилгааг багасгах уриалгыг эс хайхарсаар олон жилийг өнгөрөөсөн комисс эцсийн эцэст мэргэжилтэн, эцэг эхчүүдийн үгийг сонслоо” хэмээн Children’s Food Campaign лобби бүлэг мэдэгдлээ. Онлайн болон олон нийтийн мэдээллийн хэрэгслийн үзэгч, сонсогчидтой холбоотой

мэдээлэл бүрэн бус байгаагаас шинэ журам ойролцоогоор 25 хувийн “цоорхой”-тойг кампани өрнүүлэгч Малкольм Кларк анхааруулав. “Голдуу хүүхдүүд үздэг нэвтрүүлгийн нэлээд нь шинэ журамд хамрагдсангүй. Тэгэхээр хэрэглэгч ихтэй олон нийтийн мэдээллийн сайтын ихэнх нь шинэ журмыг үл анзааран, хуучнаараа сурталчилгаа явуулсаар байх болно” хэмээн тэрбээр өгүүллээ.

Хүүхдүүдийн үзэх дуртай нэвтрүүлгийн нэг - Britain’s Got Talent-ийн энэ оны цувралыг Shreddies хуурай зууш үйлдвэрлэдэг Nestle компани ивээн тэтгэж байгаа. Гэтэл уг нэвтрүүлэг хүүхдийн гэсэн ангилалд багтаагүй. Буудай зэрэг үр тарианы боловсруулсан, хуурай бүтээгдэхүүн болох Shreddies-ийг Nestle компани гурван төрлөөр үйлдвэрлэдэг. Аль аль нь өөх тос, чихэр, давсны агуулга ихтэй ч шинэ журамд хамаарахгүй байгааг ноён Кларк анхааруулав.

Сурталчилгааны журам нарийн мөрддөг хүнсний үйлдвэрлэлд төрөл бүрийн хориг үйлчилдэг талаар Хүнс, ундаа үйлдвэрлэгчдийн холбоо (FDF) тайлбарлав байна. “Залуу үе уламжлалт мэдээллийн хэрэгслээс шинэ, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд шилжиж буй нөхцөлд сурталчилгааны дүрэм журмыг ч өөрчлөх шаардлагатай боллоо” хэмээн тус холбооны захирал Иэн Райт өгүүлсэн юм.



© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.



Хятадын төрийн компаниуд сангийн өр төлбөрийг барагдуулахад оролцсоныхоо хариуд эрчим хүчний бизнест хувь эзэмших эрхтэй болно.

BVMC

Хятадууд Малайзын өөрийг дарахад тусална

Живан Васагар, Калорин Бинхэм

Санхүүгийн бэрхшээлд орсон Малайзын 1MDB хэмээх улсын хөрөнгө оруулалтын санд Хятад улс туслахыг зөвшөөрчээ. Тус сан Абу Дабигийн улсын эзэмшилтэй Нефтийн хөрөнгө оруулалтын компанитай/IPIC/ төлбөрийн маргаан үүсгээд байна. Эмиратын тал Малайзын сангаас 6.5 тэрбум ам.доллар нэхэмжилж буй уг маргааныг шийдвэрлэхэд Бээжин оролцохоор болсон юм. Ингэснээр 1MDB-ын өөрийг төлж эхэлнэ гэж уг хэрэг явдлыг сайн мэдэх хоёр хүн ярьжээ. Хятадын тусламж өрөнд баригдаад буй сангийн санхүүгийн байдлыг сайжруулж магадгүй юм.

Улсын хоёр сангийн харилцаа энэ оны эхээр нэн хурцдаж, 1MDB үүргээ гүйцэтгэсэн хэмээн нотлохыг оролдсон бол IPIC уг хэргийг Лондон дахь арбитраж шүүхэд өгөхөөр бэлтгэж байгаа. Анх энэ хоёр сангийн хамтын ажиллагааг

Малайз, Эмиратын стратегийн түншлэлийн бэлгэдэл хэмээн нэрлэж байв. Гэвч Эмиратын албаныхан 1MDB-аас нэг тэрбум ам.доллар залилан гаргуулж авсан гэх хэрэг мандсан тул хэрүүл маргаандаа тулаад байгаа нь энэ.

IPIC-ийн захирал асан Хадем Аль Кубайси гэгч уг хэрэгт оролцсоны учир саатуулагджээ. Түүнд ямар нэг ял тулгаагүй байгаа. Учрыг мэдэх хүмүүсийн ярьснаар 1MDB сангийнхан Бээжинд хандаж, санхүүжилтийн эх сурвалж хүссэн агаад Малайзын тал оронд нь хөрөнгийн солилцоо хийхээр тохиролцсон бололтой. Хятадын төрийн компаниуд сангийн өр төлбөрийг барагдуулахад оролцсоныхоо хариуд эрчим хүчний бизнест хувь эзэмших эрхтэй болно. Ингэснээр АНУ, Сингапур, Швейцарь зэрэг улсад шүүхэд дуудагдах дээрээ тулаад буй Малайзын Засгийн газарт учирсан санхүүгийн дарамт

суларч магадгүй юм.

1MDB сантай холбоотой хэрэг Куала Лумпур ба Вашингтоны харилцаанд сэв суулгаад буй үед Хятад, Малайзын харилцаа улам бүр нягтрах төлөвтэй. Абу Дабигийн сан болон Малайзын сангийн маргаан өнгөрсөн онд байгуулсан өрөөс чөлөөлөх гэрээнээс эхлэлтэй. IPIC нэг тэрбум ам.доллар зээлдүүлж, Малайзын өөрийн 3.5 тэрбум ам.долларыг төлөх үүрэг хүлээсэн аж. Дээр нь 1MDB-аас авах ёстой нэг тэрбум ам.долларын өөрийг өршөөсөн гэнэ.

Хариуд нь Малайзын сан зээлийн хэмжээнд дүйцэх буюу үүрэг авсан төлбөр ба зээлийн хэмжээгээр хөрөнгө шилжүүлэн өгөх ёстой байв. Гэтэл Абу Даби Малайзын сан ба Сангийн яамны эсрэг нэхэмжлэл гаргаж, өрөөс чөлөөлөх гэрээгээр үүргээ биелүүлэхийг шаарджээ. Дөрөвдүгээр сард уг шаардлага ирэхэд 1MDB

“гайхаж” байгаагаа илэрхийлсэн байна. Малайзын сан хариу мэдэгдэл хийж, “IPIC-ийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийн төлөө ажиллаж байгаагаа бүрэн хариуцлагатайгаар мэдэгдэж байна” гэжээ.

Удалгүй IPIC арбитраж шүүхэд зарга мэдүүлсний дараа 1MDB өөрийн хуулийн байр суурь бүрэн итгэлтэй байна гээд эрх зүйн хатуу хариу өгөх болно хэмээв. Хөрөнгө оруулалтын банкаар мэргэшсэн, 1MDB сангийн захирал ноён Арул Канда мэйлээр ирүүлсэн мэдээндээ “IPIC-тэй үүссэн маргааны тухайд 1MDB-ийн зүгээс өмнө мэдэгдсэн дээр нэмж хэлэх зүйл алга” хэмээн мэдсэн байна. Харин ноён Кубайсигийн хуульч тайлбар хийхээс түдгэлзэв. Ийн өрнөсөн маргаан шийдэгдвэл IPIC ба 1MDB-ийн хоорондын түвэгтэй харилцаа төгсгөл болох нь тодорхой.

FT

Альцгеймерийг эмчлэх шинэ найдвар

Клайв Куксон

Анивчсан гэрэл буюу эмийн бус аргаар Альцгеймерийн өвчнийг эмчлэх боломж байгааг Массачусетсийн технологийн их сургуулийн судалгааны тайланд дурджээ. Тодорхой тархин дахь хортой протейнийг цэвэрлэхэд тустай долгион үүсгэдэг байна. Генийн хувьд Альцгеймерийн өвчтэй байхаар програмчлагдсан хулгана дээр туршилт хийж үзээд МТИС-ийн неврологи судлаачид секундэд 40 удаа анивчдаг гэрэл өвчний улмаас дарагдсан гамма хэлбэлзэлтэй долгионыг сэргээдгийг нээжээ.

Долоо хоногийн турш өдөрт нэг цаг гэрлээр эмчлэхэд Альцгеймертэй холбоотой хорт амилоид болон Тау протейний түвшин буурч байгаа нь ажиглагдсан. Уг судалгаа Nature сэтгүүлийн сүүлийн дугаарт нийтлэгдсэн байна.


Судлаачид Cognito Therapeutics нэртэй компани байгуулж, туршилтынхаа үр дүнг зах зээлд гаргахаар төлөвлөжээ. Түүнчлэн Америкийн Хүнс ба эмийн захиргаатай хамтран эмнэл зүйн туршилт хийх асуудлыг ярилцаж байгаа аж.

Төслийн удирдагч профессор Ли Хуэй Цай “Хэрвээ хүмүүс дээр хулганатай ижил үр дүн үзүүлбэл эмчилгээний боломж асар өргөн юм. Учир нь эмийн бус бөгөөд маш хүргэмжтэй гэж бодож байна. Гэвч хэрвээ гэдэг нь томоохон асуудал. Хулгана дээр болж байгаа зүйл хүн дээр болохгүй байх тохиолдол олон” гэжээ. Саяхан доктор Эли Лиллийн боловсруулсан Solanezumab хэмээх эмээр Альцгеймерийн өвчнийг эмчлэх эмнэл зүйн туршилт хийсэн боловч амжилтад хүрээгүй.

Гэхдээ МТИС-ийн судалгаа эмийн бус эмчилгээ санал болгож буй агаад профессор Цайн хэлснээр “Өмнөх бүх оролдлогоос үндсээрээ ялгаатай”

юм. Тэрбээр цааш нь “Нэвтрэлгүйгээр мэдрэлийг цочроох арга нь хүний биед химийн бодис буюу антибиотик шингээх шаардлагагүй. Үүний зэрэгцээ тархины цусны судал дахь саад тотгор болон гаж нөлөөний талаар санаа зовох хэрэггүй болно. Бид тархины нейрон болон бусад эсийг идэвхжүүлж, өөрт нь оршдог эдгээх чанарыг сэргээдэг” хэмээн өгүүлэв.

Судлаачид анх optogenetics гэж нэрлэдэг үл нэвтрэх аргыг шилэн мяндас ашиглан хулганы тархин дахь тодорхой нейронуудыг туяагаар шууд шарах замаар хэрэгжүүлсэн байна. Тэд 40 герц /секунд дэх давтамж/ давтамжтай туяа тархины гамма долгионыг сэргээхэд хамгийн тохиромжтой болохыг тогтоов. Ийм долгион Альцгеймерийн өвчин үүсгэдэг хорт протейнуудыг цэвэрлэх чадвартай аж. Судлаачид үл нэвтрэх туршилтаа үргэлжлүүлж,



хулганын торонд LED гэрлийн тууз байрлуулжээ. Ингээд долоо хоног илүү хугацаанд өдөр бүр нэг цагаар гэрлийн эмчилгээ хийхэд өвчтэй хулганын тархин дахь амилоид болон Тау протейн хэмжээ буурсан байна.

Эмчилгээний гэрлийн анивчих давтамж диско баарны гэрлийнхээс түргэн боловч заавал хурц байх шаардлагагүй. Судалгаанд оролцоогүй Альцгеймерийн мэргэжилтнүүд шинэ нээлтийг талархан хүлээн авч, хүн дээр туршиж үзэх ёстойг сануулсан байна. Тухайлбал, Альцгеймерийн нийгэмлэгийн судалгааны захирал Даг Браун “Ийм өвчтэй хүмүүсийн хувьд энэ арга үр нөлөөгөө түргэн өгөхийг боловч судалгааны шинэ чиглэлийг нээж болох юм” хэмээн үнэлжээ.

FT

Туркийн арми дахь цэвэрлэгээ НАТО-г сулруулсан

Артур Бисли

Умард Атлантын цэргийн эвслийн Европ дахь хүчний командлагч Куртис Скапарротти Туркэд болсон цэргийн эргэлтийн ажиллагаанд оролцсон гэх үндэслэлээр туршлагатай офицеруудийг халсан нь НАТО-гийн чадамжид муугаар нөлөөллөө хэмээв. Туркийн дээд тушаалын 150 орчим цэргийн албан хаагчийг НАТО-гаас татсан буюу чөлөөнд гаргасныг энд тэмдэглэжээ. Тэрбээр “Эдгээр офицер НАТО дахь үүргээ сайн гүйцэтгэж байсан. Миний хүмүүс авьяастай, чадварлаг ажилтнууд. Одоо тэднийг чөлөөлсөн хэмжээгээр чадамж, туршлага, ажлын ачаалал алдагдлаа” хэмээн онцлов.

Командлагчаас түүний удирдлагад ажиллаж байсан Туркийн офицерууд эргэлт хийх төлөвлөгөөнд оролцсон гэх сэжиг төрсөн үү хэмээн асуухад “Үгүй” гэж хариулсан юм. Генерал Скапарротти бол Америкийн армийн хамгийн өндөр албан тушаалтны нэг бөгөөд Солонгос, Афганистанд алба хааж байсан туршлагатай хүн. Тэрбээр офицеруудыг халсан нь Туркийн армийн өөрийнх нь цэргийн чадамжид муугаар нөлөөллөө гэсэн байна. Тус улсын зэвсэгт хүчин эвсэл дотроо томоохонд тооцогддог

агаад Иран, Ирак, Сирийн хил дээр НАТО-гийн стратегийг хэрэгжүүлдэг юм.

Генерал цааш нь “Толдуу дээд тушаалтнуудыг халсан тул үр дагавар нь илт мэдэгдэж, хуримтлагдсан туршлага алдагдлаа. Иймээс чадамж суларсан тал бий. Бид НАТО-гийн хамтрагчид, шинэ удирдлагатай харилцаагаа бэхжүүлэх ёстой. Энэ үйл явц урагшилж байгаа ч цаг хугацаа хэрэгтэй” гэжээ. Түүний үгээр Туркийн Батлан хамгаалахын сайд Хулуси Акартай хийсэн яриа хэлэлцээ НАТО-гийн зүгээс түгшүүрийг арилгасан гэнэ.

Умард Атлантын цэргийн эвсэл дэх Туркийн офицеруудыг чөлөөлөх арга хэмжээ Анкара ба Европын холбооны харилцаа хурцдаж буй цаг үетэй зэрэгцэж байна. Брюссель Ерөнхийлөгч Эрдоаны талаар байр сууриа чангатгаж байгаа бол Туркийн төрийн тэргүүн Европ руу гурван сая цагаачийг оруулна хэмээн сүрдүүлсэн. Генерал Скапарроттийн ярьснаар НАТО-гаас татагдсан Туркийн офицерууд голдуу хурандаа, дэд хурандаа цолтой агаад асар их туршлагатай, дадлага сургуулилтад чухал үүрэгтэй хүмүүс байжээ.

Халагдсан хүмүүсийн

Умард Атлантын цэргийн эвсэл дэх Туркийн офицеруудыг чөлөөлөх арга хэмжээ Анкара ба Европын холбооны харилцаа хурцдаж буй цаг үетэй зэрэгцэж байна.

оронд Туркийн талаас залуу офицеруудыг сонгон илгээж буй авч дөнгөж хагасынх нь албан тушаалыг дүүргээд байгаа аж. Сүүлийн сард НАТО-д ажиллахаар ирсэн Туркийн зарим офицер буцаж харихын оронд Европт үлдэх сонирхолтой нь ажиглагджээ. Гэхдээ орогнол

хүссэн өргөдлийг авч үзэх нь үндэсний Засгийн газруудын эрхлэх ажил хэмээн эвслийн төлөөлөгч мэдэгдэв.

Генерал Скапарротти ярихдаа офицерууд болон тэдний гэр бүлийг эх орондоо буцаж очиход нь сайн хандах талаар Туркийн Засгийн газарт

хүсэлт тавьж, нааштай хариу авснаа дурдсан байна. Тэрбээр “Бидэнтэй ажилласан хүмүүст юу тохиолдож болох тухайд сэтгэл түгшиж байна. Би генерал Акартай ярилцахдаа өөрийн түгшүүрийг илэрхийлэхэд тэд хуулийг дагаж мөрдөнө, хүмүүст мөн тийм байдлаар

хандана гэсэн. Би түүнд бас офицеруудын гэр бүлд анхаарал тавихыг сануулсан. Манайд ажиллаж байгаа хүмүүс зарим тохиолдолд ирээдүйд юу болох талаар ямар ч ойлголтгүй байна. Би үүнд санаа зовж байгаа” хэмээн өгүүлжээ.

FT

BVMC



Эдийн засаг

ХҮНД ҮЙЛДВЭР

Экспортыг эрчимжүүлэх хөтөлбөртэй танилц

“Зэс хайлуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтад дөрвөн жилийн хугацаа шаардлагатай

“Зэс” хөтөлбөр нь “Зэс хайлуулах үйлдвэр”-ийн эхлэл. Хөтөлбөрийн хүрээнд хайлах, цэвэршүүлэх технологи судлах, энэ чиглэлээр туршлага солилцох хэрэгцээ, шаардлага ургаж байгаа аж. “Төр, хувийн хэвшлийн оролцооны үндсэн дээр “Зэс” хөтөлбөрийн зорилт биелэх боломжтой” хэмээн “Монголын экспортлогчдын холбоо”-ны удирдах зөвлөлийн гишүүн Д.Галсандорж тэмдэглэсэн.

Төлөвлөж байгаа үйлдвэрийн техник, эдийн засгийн үндэслэлээр хөрөнгө оруулалт нь 798.8 сая ам.доллар гэсэн тооцоо гарсан. Хөрөнгө оруулалт далаа мега төсөл нь цогцолбор үйлдвэр болж хөгжих юм. Үүнд ойролцоогоор нэг тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай. Цогцолбор учраас хөрөнгө оруулалт тодорхой хэмжээгээр нэмэгдэж байгаа нь энэ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хүнд үйлдвэрийн бодлогын газрын дарга Б.Баатарсүх “Зэс хайлуулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажилд дөрвөн жилийн хугацаа шаардлагатай. Энэ хугацаанд барьж дуусгана” хэмээн онцолсон. Тэрбээр “Үйлдвэр ашиглалтад ормогц катодын зэсээ гадагшаа экспортлох юм. Жилд 120 орчим мянган тонн цэвэр катодын зэс



ВВМ©

үйлдвэрлэж, олон улсын зах зээлд гаргана” гэв.

Катодын зэсийг цаашид боловсруулж зэс болон гуулин цувимал бэлдэцийн үйлдвэр, улмаар эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хөгжүүлэх боломжтой аж.

Нөгөөтэйгүүр энэ хөтөлбөрийн хүрээнд хөрсөн дээр амилах үйлдвэрийг дагаж гарах асуудлыг шийдвэрлэх шаардлагатай болж байгаа юм. Энэ нь зэсийн баяжмал хайлуулах явцад ялгарах хүхэрт хий. Үүнийг хүхрийн хүчил болон хүхэр үйлдвэрлэх замаар шийддэг аж. Төслийн хүрээнд жилд 530 мянган тонн зэсийн баяжмал боловсруулж, 120 мянган тонн катодын зэс, 200 мянган тонн хүхрийн хүчил, 110

мянган тонн элементийн хүхэр тус тус үйлдвэрлэхээр тооцжээ.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт багтсан “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр”-ийн төслийг БНХАУ-ын Өнгөт металлургийн үйлдвэрийн зураг төслийн институт боловсруулсан. Цэвэр зэс үйлдвэрлэх, зэсээр хийсэн эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх үндэс суурийг тавих нь уг төслийн үндсэн зорилго. Өнгөт металлургийн салбарт хэрэглээгээр хөнгөн цагааны дараа ордог нь зэс. Хэрэгжүүлэхээр зэхэж байгаа дээрх үйлдвэрийн үр дүнд 800 ажлын байр шинээр бий болох тооцоолол гарсан.

Экспортын болон импортыг

» “Зэс” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байгааг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас онцолж байна.

» Сүүлийн зургаан жилийн хугацаанд геологийн судалгааны ажлын үр дүнд зэсийн 80 орчим илрэл, 300 гаруй эрдэсжсэн цэгийг тогтоожээ.

» Зэсийн баяжмалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх нь экспортын орлого өсөх боломж.

орлох бүтээгдэхүүний нэр төрлийг шинээр бий болгох нь “Зэс” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн шалтгаан. Энэ нь манай улсын гадаад худалдааны тэнцэлд эерэг нөлөө үзүүлэх үр ашигтай. Мөн үйлдвэрийг дагалдан туслах болон жижиг, дунд үйлдвэр хөгжих боломжтойг уг төсөлд онцолсон байгаа.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж “Түүхий эд бэлтгэгч орноос үйлдвэрлэгч орон болохоор зорьж байна” хэмээн онцолсон. Үйлдвэрлэлд байгаль орчин, нийгэмд хал багатай техник, технологи нэвтрүүлэх бөгөөд эцсийн бүтээгдэхүүн экспортлогч орон болохоор “Зэс” хөтөлбөр чиглэж байна. [НМ]

ЗГМ ТОВЧХОН

» ХҮНСНИЙ ҮНЭ

300

Төгрөг. Үхрийн ястай махны үнэ өнгөрсөн долоо хоногт 5.5 хувь буюу 300 төгрөгөөр буурч, 5200 төгрөгт хүрчээ. Мөн төмсний үнэ тав, манжингийнх 30 төгрөгөөр буурсан байна. Харин луувангийн үнэ 140, байцаа 150 төгрөгөөр өсчээ.

» ГАЗРЫН ТОС

19.5

Хувь. ОХУ-ын “Роснефть” компанийн 19.5 хувийг Катарын баялгийн сан болон “Glencore” хамтран худалдаж авахаар хэлэлцэж байна. Худалдан авалтын үнийн дүн 11.3 тэрбум ам.доллараар хэмжигдэж байгаа аж.

» ТАТВАР

12.1

Хувь. Энэ оны эхний арван сарын байдлаар онцгой албан татварын орлого 57.7 тэрбум төгрөг буюу 12.1 хувиар өссөн байна.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ, доллар	2474.86
Евро	2651.57
Япон, иен	21.64
ОХУ, рубль	38.73
БНХАУ юань	359.17
БНСУ вон	2.12

ЗАСАГ ДАРГА ЯРЬЖ БАЙНА

Д.Галсандондог: Ногоон хөгжлийн загвар аймаг болно

Ирэх онд 150 км хатуу хучилттай замын ажил эхлүүлнэ

Б.Баяртогтох
@bayartogtokhZGM

Ховд аймгийн Засаг дарга Д.Галсандондогтой ярилцлаа. Ховд аймаг жижиг, дунд үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлсэн, иргэдээ ажлын байртай, амьдрах ая тухтай орчинтой, үйлдвэрлэл, бизнест ээлтэй, ногоон хөгжлийн загвар аймаг болохоор хөгжлийн бодлогоо тодорхойлсныг тэрбээр онцолсон юм.

-Аймгийн хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл ажил хэрхэн хангагдав. Сумдад өвөлжилт хэр байна вэ?

-Өвөлжилтийн байдал хаа сайгүй анхаарал хандуулж байна. Манай аймгийн хувьд Засаг даргын захирамж гарч, өвөлжилтийн ажлын хэсэг тусгайлан ажилласан. Үүний үр дүнд бэлтгэл ажлаа цаг хугацаанд нь бүрэн хийсэн. Төлөвлөгөө ёсоор 64 мянган тонн хадлан, тэжээл бэлтгэхээс 60 гаруй мянгыг хурааж авсан. Малчид энэ жил өвөлжөөндөө нэлээд хожуу буусан. Энэ нь манай аймагт бог малын мялзан төст халдварт өвчин гарсангай холбоотой. Үүнийг 40 орчим хоногийн хугацаанд дарж, бүх малаа вакцинд хамруулсны дараа малчид маань өвөлжөөндөө буусан юм. Засгийн газрын зүгээс үүссэн нөхцөл байдал онцгой анхаарал хандуулж, цаг алдалгүй ажилласан. Аймгийн

хэмжээнд 17 сумаас гуравт нь өвөлжилт хүндрэлтэй байна. Тодруулбал, Алтайн нурууны өвөр бэлд байдаг Булган, Уенч, Алтай суманд цас их орсон. Харин бусад сумын хувьд хүндрэл гарсан зүйлгүй байна.

-Бог малын халдварт өвчин дахиж гарахаас урьдчилан сэргийлэх ажлыг хэрхэн хэрэгжүүлсэн бэ?

-Эрсдэл бол байгаа. Тиймээс Улсын онцгой комисс болон Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хамтарсан ажлын хэсэг хоёр удаа манай аймгийн өвчний голомтод ажилласан. Нийт мал сүргийн 70 хувийг үр өвчний вакцинд хамруулсан. Үлдсэн 30 хувьд нь байгалийн дархлаа тогтсон гэж үзэж байгаа. Өвчин гараад өнгөрөөхөд малд дархлаа тогтдог юм байна. Иймээс 100 хувь дархлаа тогтсон гэж үзсэн. Манай аймагт нийт 2.8 сая бог мал бий. Бог малын хувьд төст өвчнөөр хонь, ямаа өвчилдөг. Хэдийгээр вакцинд хамруулж, дархлаа тогтсон ч ирэх хавар мал төллөх үед шинэ төлөөр дамжин гарч ирж магадгүй гэсэн болгоомжлол бий. Тиймээс төл малыг вакцинд хамруулахаар нөөц бэлдсэн. Энэ тохиолдолд бүрэн устдаг.

-Аймаг бүр хөгжлийн тулгуур салбараа тодорхойлж, бодлогоо ч түүндээ нийцүүлж байгаа. Тухайлбал, танай аймгийн хувьд аль салбарт найдвар тавьж байна вэ?

-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн II хуралдаан энэ сарын эхээр болсон. Тус хурлаар Засаг даргын 2016-2020 он хүртэлх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэлэлцэж, баталсан. Засаг даргын мөрийн хөтөлбөр дөрвөн бүлэг, 22 дэд бүлэг, 98 зорилттой. Аймгийн хөгжлийн тулгуур бодлого энэхүү баримт бичигт маш тодорхой

тусгагдсан. Ховд аймаг жижиг, дунд үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлсэн, иргэдээ ажлын байртай, амьдрах ая тухтай орчинтой, үйлдвэрлэл, бизнест ээлтэй, ногоон хөгжлийн загвар аймаг болгохоор хөгжлийн бодлогоо тодорхойллоо. Гол нь ажлын байрыг нэмэгдүүлж, өрхийн орлогыг дээшлүүлэхэд бодлого маань чиглэх юм. Баруун бүсийн тулгуур төвийн хувьд энэ статусаа улам бэхжүүлж ажиллах зорилт үндсэндээ дэвшүүлж байгаа. Аймгийн Засаг дарга нь баруун бүсийн зөвлөлийн дарга гэж явдаг. Хуучин бүсчилсэн хөгжлийн тухай хууль одоогийнхоос илүү хүчтэй байхад нэлээд өргөн хүрээнд уг зөвлөл ажилладаг байсан. Харин сүүлийн жилүүдэд суларсан. Би хувьдаа бүсчилсэн хөгжлийг сэргээх шаардлагатай гэж үздэг хүний нэг. Тэр хүрээнд гол бодлогоо үүнд хандуулсан. Аймгийн тулгуур салбарын хувьд жижиг, дунд үйлдвэрлэлд ихээхэн ач холбогдол өгч байна. Орон нутагтаа хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, бүс нутгийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, боловсруулах, нэмүү өртөг шингээж, эцсийн бүтээгдэхүүн бий болгох шаардлага байгаа. Ажлын байрыг олноор бий болгох хамгийн боломжтой салбар бол хөнгөн үйлдвэрлэлийн салбар гэж харж байгаа. Түүний дотор жижиг, дунд үйлдвэрлэлд түлхүү ач холбогдол өгч байна.

-Орлого нэмэгдүүлэх, шинээр ажлын байр бий болгох хоёр дахь гарц, боломжийг хэрхэн тодорхойлж байгаа вэ?

-Бичил уурхайг хөгжүүлэх сонирхол байгаа. Энэ нь хариуцлагатай уул уурхайн зарчмаар явагдана гэсэн үг. Баруун таван аймагт уул уурхай нэлээд сул хөгжсөн тул анхаарал хандуулж

байгаа хэрэг. Геологи, хайгуулын судалгаа маш бага хийгдсэн. Хаана, ямар ашигт малтмал байгаа, хэр хэмжээний нөөцтэй, ашиглах боломжтой эсэх нь одоо ч бүрхэг. Тиймээс уул уурхайн чиглэлээр Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хэрэгжүүлэхээр тусгагдсан ажлыг орон нутгийн зүгээс боломжит түвшинд дэмжиж ажиллана.

Ажлын байр нэмэгдүүлэх хамгийн боломжтой салбар бол хөнгөн үйлдвэрлэл

-Та ногоон хөгжлийн загвар аймаг болно гэж хэллээ. Энэ хүрээнд бодлого үндсэндээ зангидагдаж байгаа гэж үзэж болох уу?

-Тийм ээ. Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон Ховд аймгийг 2030 он хүртэл хөгжүүлэх төлөвлөгөөний гол цөм нь ногоон хөгжил. Дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага ч үүнд чиглэж байна. Ногоон хөгжлийн хөтөлбөрөө өнгөрсөн сард хуралдсан аймгийн ИТХ-ын ээлжит бус чуулганаар баталсан. Ногоон хөгжил бол тогтвортой хөгжих зам. Баталсан хөтөлбөрийнхөө хүрээнд үйл ажиллагаагаа нийцүүлж ажиллана. Ховд аймгийг хөгжүүлэх төлөвлөгөөг өнгөрсөн онд ИТХ-аар баталсан. Энэ хөтөлбөрийг цаашид мөрдөнө. Байгаль орчинд ээлтэй, ногоон хөгжлийг зарчмаар болгож байгаа. Өмнө нь хийсэн, нарийн тооцоо судалгаатай, үндэслэл сайтай хөтөлбөрийг үгүйсгэх бус, дэмжиж, үр ашгийг нь гаргахын төлөө зорьж байна.

Ер нь бодлогын залгамж холбоо их чухал.

-Аймгуудын өрсөлдөх чадварын 2015 оны тайлангийн үзүүлэлтээр Ховд аймаг 11 дүгээрт эрэмбэлэгдсэн. Тус судалгаагаар шаардлага тантай аймагт тулгарч буй. Орон нутгийн удирдлагын зүгээс ирэх жилүүдэд ямар ахиц, дэвшил гаргахаар төлөвлөж байна вэ?

-Өрсөлдөх чадвар дээр бусад үзүүлэлтээ ч өсгөхийн төлөө ажиллана. Хамгийн гол нь ажлын байр, ажилгүйдэл тулгамдсан асуудал хэвээр байна. Одоо ажилд орох хүсэлтэй маш олон хүний өргөдөл ирж байгаа. Аймагт үйл ажиллагаа явуулж байгаа төсөвт байгууллага маань орон тооны хувьд хэмжээ, хязгаартай. Тиймээс ажилтай болгох нь амаргүй. Гэхдээ ирэх хугацаанд дээр дурдсан ажлын байрыг нэмэгдүүлэх зорилгодоо тууштай анхаарна гэдгээ энэ дашрамд хэлье. Манай аймагт багшийн мэргэжилтэй хүмүүсийн илүүдэл нэлээд бий. Энэ нь Ховд их сургууль багш мэргэжилтэн түлхүү бэлдэж ирсэнтэй холбоотой байх. Цаашид шинээр бэлтгэх боловсон хүчнийг шаардлагатай байгаа мэргэжлээр сургах, тэр чиглэлийн нарийн мэргэжлийн боловсон хүчин бас дутагдалтай.

-Орон нутгийн хэмжээнд шилжих хөдөлгөөн саарсан уу, эсвэл хэвээр байгаа юу?

-Шилжилт хөдөлгөөнийг нарийн судалж, тодорхой хэлэхэд одоогоор хүндрэлтэй байна. Ажиллахад шилжилт хөдөлгөөн харьцангуй саарсан байгаа. УИХ-ын сонгуультай

холбоотойгоор орон нутагт энэ зун шилжилт хөдөлгөөн нэлээд эрчимжсэн. Үүнтэй холбоотойгоор хотоос аймаг руу чиглэсэн урсгал манай аймагт нэмэгдсэн. Нэгэнт сонгууль болж дууссан болохоор энэ байдал цэгцрэх байх. Аль нь одоо шилжиж байгааг дэнсэлж хэлэхэд хэцүү. Ирэх жилээс илүү бодит тоо хэлэх боломжтой болно.

-Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг сайжруулах шаардлага бий. Энэ хүрээнд ямар зарчим баримталж ажиллах вэ?

-Бизнест ээлтэй аймаг болохоор зорьж байгаа. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг улам идэвхжүүлж, бизнес эрхлэхэд гардаг хүндрэл, бэрхшээлийг арилгахын төлөө ажиллаж байна. Ажлын байрыг нэмэгдүүлэх, иргэдийн бодит орлого нэмэгдэх, орон нутаг хөгжлөө урагшлуулахад хувийн хөдөлгөөн чухал нөлөөтэй. Иймээс баялаг бүтээгчдээ дэмжиж ажиллах учиртай.

-Та бичил уурхайг хөгжүүлэх талаар өмнө нь дурдсан шүү дээ. Уул уурхайг хөгжүүлэх ямар бодлого баримтлах вэ?

-Манай аймагт үйл ажиллагаа явуулж байгаа хамгийн том уурхай нь Хөшөөт. Ордын нөөц болон эдийн засгийн өгөөжөөрөө хамгийн том нь. Уурхайн ашиглалтыг хариуцлагатай эхлүүлсэн. Энэ нь цаашид ч хэвээр хадгалагдана гэж үзэж байгаа. БНХАУ-руу тусгай технологийн хатуу хучилттай авто замаар нүүрсээ тээвэрлэж байна. Хөшөөтийг эс тооцвол томоохон уурхай байхгүй. Бичил уурхайг хариуцлагатай, ил тод байдлаар хөгжүүлэх бололцоотой. Үүнийг шаардлага болгож ажиллана. Одоогоор шинээр нөөц нь тогтоогдсон томоохон орд мэдэгдсэн юмгүй байна. ►12

Эдийн засаг

ЗАСАГ ДАРГА ЯРЬЖ БАЙНА

Бүсчилсэн хөгжлийг сэргээх шаардлагатай

«11 -Аялал жуулчлалын салбарт орон нутгийн зүгээс хэрхэн анхаарал хандуулах вэ?»

-Манай аймаг аялал жуулчлалыг хөгжүүлэх өргөн боломжтой. Аймгийн ногоон хөгжлийн тэргүүлэх салбарын нэг нь “үл үзэгдэх экспорт” буюу аялал жуулчлал байх юм. Ялангуяа орон нутгийн орлогын гол эх үүсвэр байна. Мөн байнгын болон улирлын чанартай ажлын байр энэ салбарт бий болгоно. Байгаль, түүх, соёлын аялал жуулчлалыг ирэх жилүүдэд хөгжүүлэхээр цөөнгүй ажил төлөвлөн хэрэгжүүлэх гэж байгаа. Өнгөрсөн хугацаанд аялал жуулчлал манай аймагт урсгалаараа буюу тодорхой түвшинд хөгжиж ирсэн. Жуулчдын урсгал жил ирэх тусам нэмэгдэж байгаа. Энэ нь бидэнд томоохон итгэл, найдвар төрүүлж байгаа.

Аялал жуулчлалын бүс нутаг болж хөгжих хүрээнд орон нутгаа сурталчлах, түүх, соёлоо таниулах ажлыг нэлээд эрчимжүүлэх шаардлага байна. Төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа аялал жуулчлалын салбарт илүү хөгжих бололцоотой. Аймгийн зүгээс нисэх онгоцны буудлаа өргөтгөх, үйлчилгээний чанар, стандартаа сайжруулах, музейн сан хөмрөгийг баяжуулж, сэргээн засварлахад анхаарна. Тухайн үзмэр тойрсон үйлчилгээ, тав тухай бид нэг талаар орхигдуулсан тал бий. Энэ нь жуулчдад таагүй сэтгэгдэл үлдээж байна. Тиймээс жижиг гэлтгүй харилцааны соёл ч анхаарах шаардлага гарч байгаагүйгсгэхгүй.

-Та ямар эдийн засгийн чадавхтай аймаг хүлээж авсан бэ. Эдийн засгийн байдал



С.Батсайхан / ЗГМ©

амаргүй байгаа нь олон ажил хийх, хэрэгжүүлэхэд саад болж байгаа ч боломж, бололцоог эрэлхийлж байгаа байх?

-Улс орны хэмжээнд үүссэн хүндрэл манай аймгийг ч тойрсонгүй. Хүндрэл бол байсан. Болгох, бүтээх талаас нь боломж, бололцоог эрэлхийлж байна. Эдийн засаг хямралтай гээд зүгээр сууж болохгүй. Хүндрэлийг даван туулах ёстой. Миний хувьд хүмүүсийн өмнө нь хийж, хэрэгжүүлсэн ажилтай зууралдаад байх бус, урагшаа харж ажиллана гэж бодож байгаа. Нөхцөл байдал нь харилцан адилгүй болохоор зөв, буруу гэж шууд дүгнэх нь төдийлэн оновчтой биш. Ирээдүйгээ харж, төлөвлөсөн ажлаа хэрэгжүүлэхийн төлөө л зүтгэж байна. Бид өнгөрсөн

асуудалтай ноцолдож, цаг их алддаг. Үүнийг давтааргүй байгаа юм. Эцсийн дүндээ нутаг орноо хөгжүүлэх, Монгол Улсын хөгжилд чөдөр тушаа бус, нэмэр тус болох нь чухал.

-Булганы боомт баруун бүсийн гадаад худалдааны коридор. Уг боомтын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд ямар бодлого баримталж ажиллах вэ?

-Булган боомт олон жилийн өмнөөс хөгжсөн. Байнгын үйл ажиллагаатай. Тус боомтоор баруун таван аймгийн иргэд худалдаа, арижаа хийж ирсэн. Олон улсын боомт учраас эдийн засгийн үр ашиг нь одоо байгаагаас хэд дахин нэмэгдэх боломжтой. Боомтын үр ашгийг нэмэгдүүлэх хүрээнд БНХАУ-ын Шинжаан Уйгурын Өөртөө

засах орны Алтай аймгийн удирдлагатай уулзаж, тодорхой шийдэлд хүрч чадсан. Хятадын талаас хамааралтай хүндрэл байсан. Үүнийг хоёр сар орчмын хугацаанд хэлэлцэж, нааштай хариу хүлээж авсан. Такейшкен-Булган боомтын хооронд ачаа тээврийн зам барихаар төлөвлөж байна. Энэ нь гадаад худалдааг тэлэхэд эерэг нөлөө үзүүлнэ гэж хоёр тал онцолж байгаа.

Булганы шалган нэвтрүүлэх боомтоор тээврийн хэрэгсэл нэвтрэн Такейшкены худалдааны бүсэд очиход бүртгэлийн карт, хонох хашааны түрээс, чанарын мөнгө, тээврийн газрын татвар хураамж төлдөг. Иргэдээс ирсэн санал, хүсэлтийн дагуу олон удаагийн уулзалт хийж, үр дүнд нь татвар хураамжийн өртгийг бууруулсан. Тухайлбал, 8000

юанийн бараа худалдаж авсан иргэдийн тээврийн хэрэгслээс татвар хураамж авахгүй байхаар болсон. Мөн хоёр улсын хилээр суудлын тэрэг чөлөөтэй зорчих боломжийг бүрдүүлж өгсөн. Энэ нь баруун бүсийн нийт иргэдийн өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхэд түлхэц болсон эхний алхам болж чадсан. Булган боомтын хил гаалийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, өрсөлдөх чадвартай болгох хэрэгцээ, шаардлага их байна. Байтаг боомт жигд ажиллах үед Булган боомт дээр гардаг хүнд суртал багасаж, боомт хоорондын ажлын уялдаа, холбоо илүү сайжрах байх. Энэ нь илүү таатай боломжийг бий болгоно гэж найдаж байгаа.

Үүний зарим нь ирэх онд үргэлжилнэ. Энэ болгон нь орон нутагт хөрөнгө оруулалт болж, үр дүн нь гарч байгаа. Гадаад харилцаа, хамтын ажиллагаагаар орон нутаг өөрсдийн эрх мэдэл, чиг үүргийн хүрээнд тэлэх зорилготой ажиллаж байна. Энэ хүрээнд ОХУ-ын мужийн Новосибирск хотод болсон “Монгол-Оросын хамтын ажиллагаа-2016” эдийн засгийн чуулга уулзалтад оролцлоо. Мөн БНХАУ-ын Үрэмч хотод жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Хятад-Еврази-2016” арга хэмжээнд оролцохын зэрэгцээ ажил хэргийн уулзалтыг энэ үеэр хийсэн. Худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалт, техник, технологийн харилцаа, хамтын ажиллагааг өргөтгөх чиглэлд багагүй ажлын эхлэл үүгээр тавигдсан.


Ховд аймаг БНХАУ-тай хоёр боомтоор хиллэдэг. Үүний нэг нь Байтаг боомт. Уг боомтыг байнгын үйл ажиллагаатай болгохоор яриа, хэлэлцээр хийсэн. Хамтын ажиллагааны томоохон ажлын нэг нь Байтаг боомтоос Булган сумын зам хүрэх 120 км хатуу хучилттай авто замыг үнэ төлбөргүйгээр Шинжааны Чонж аймгийн зүгээс хөрөнгө гаргаж, тавьж өгөхөөр болсон. Энэ нь найрамдлын зам гэдэг утгаараа манай улсаас ямар нэгэн төсөв, хөрөнгө гарахгүй. Мөнгөн дүнгээр 80 гаруй тэрбум төгрөгийн ажил хийгдэх юм. Бүтээн байгуулалтын ажил ирэх оны гуравдугаар сард эхэлнэ. Азийн хөгжлийн банк шинээр нийт 50 км авто замын ажлыг хийж өгөхөөр болсон. Ховд ойрын жилд 170 км авто зам шинээр ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Дэд бүтцийн томоохон бүтээн байгуулалт ирэх жил эрчимжих юм. [ЗГМ]

Хөгжилд чөдөр тушаа бус, нэмэр тус болох нь чухал

-Улсын нэгдсэн төсвөөс гадна олон улсын дэмжлэгтэй төсөл, хөтөлбөр Ховд аймагт хэрхэж байна вэ. Тухайлбал, Азийн хөгжлийн банкны орон нутгийн хөгжлийг дэмжсэн төсөл бий юү?

-Манай аймагт бүс нутгийн шинж чанартай авто замын томоохон төсөл хөтөлбөр хэрэгжиж, дуусах шатандаа орж байгаа. Уг төсөл нь Азийн хөгжлийн банкны дэмжлэгээр хэрэгжсэн. Мөн эрчим хүчний алдагдлыг бууруулах чиглэлийн төсөл хэрэгжээд, одоо өндөрлөж байна. Эдгээрээс гадна бичил уурхай, агаар болон хөрсний бохирдлын чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжиж байгаа.

Азийн хувьцаануудын ханш өслөө



Shanghai Composite индекс сүүлийн нэг сард (нэгжээр)

Ази, Номхон далайн бүсийн хөрөнгийн зах зээлийн жишиг индекс пүрвэс гарагт 1.2 хувиар өслөө. Дэлхийн тэргүүлэх эдийн засаг АНУ-ын хувьцаануудын ханш өссөн. Энэ нь тус улсын худалдааны гол түнш Азийг дэмжсэн байна. Бас БНХАУ-ын гадаад худалдааны үзүүлэлт сайн гарсан нь эергээр нөлөөлжээ. Австралийн жишиг S&P 200 индекс наймдугаар сараас

хойших дээд цэгтээ хүрвэ. Японы хувьцаануудын ханш гурван өдөр дараалан өсөж, нийт 0.9 хувиар чангарлаа. Өсөлтийг “SoftBank” группийн үнэт цаасны ханшийн тэлэлт тэргүүлжээ. Тус группийн хувьцааны ханш энэ долоо хоногт нийт 12 хувь чангараад байгаа. Тэрчлэн БНСУ-ын Hang Seng, Хонконгийн хөрөнгийн зах зээлийн жишиг индекс тус бүр 0.7 хувиар дээшиллээ. [ЗГМ]

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

ТАНАЙ КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ ЭНД БАЙРЛАЖ БОЛНО

99903584, 99903581

НЭР	СИМБОЛ	БИРЖ	ВАЛЮТ	ХАНШ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
RIO TINTO	RIO	ASX	AUD	62.73	▲ +3.12%	12/8/2016
WOLF PETROLEUM	WOF	ASX	AUD	0.025	▲ +4.17%	12/8/2016
PETRO MATAD	MATD	LON	GBX	7.925	▲ +3.26%	12/8/2016
ASPIRE MINING	AKM	ASX	AUD	0.034	▲ +3.03%	12/8/2016
GUILDFORD COAL	GUF	ASX	AUD	0.013	▼ -7.69%	12/8/2016
PROPHECY DEVELOPMENT	PCY	TSX	CAD	3.21	▼ -4.18%	12/8/2016
TURQUOISE HILL RESOURCES	TRQ	TSX	CAD	4.62	▲ +1.09%	12/8/2016
SOUTHGObI RESOURCES	SGQ	TSX	CAD	0.31	▼ -4.62%	12/8/2016
XANADU MINES	XAM	ASX	AUD	0.2	▲ +5.26%	12/8/2016
ENTREE GOLD	ETG	TSX	CAD	0.42	▼ -9.52%	12/8/2016

НЭР	СИМБОЛ	НЭГЖ	ХАНШ (\$)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛТНЫ СПОТ	XAU	унци	1174.79	▼ -0.08%	12/8/2016
ЦАГААН АЛТ	PLA	унци	950.4	▲ +0.76%	12/8/2016
МӨНГӨ	SIA	унци	17.16	▼ -0.67%	12/8/2016
ЗЭС (COMEX)	HGA	фунт	262.6	▼ -0.68%	12/8/2016
ТӨМРИЙН ХҮДЭР	TIOA	тонн	79.07	▼ -0.16%	12/8/2016
WTI ТОС	CLA	баррель	49.9	▲ +0.26%	12/8/2016
БРЕНТ	COA	баррель	53.19	▲ +0.36%	12/8/2016
БЕНЗИН	XBA		150.91	▲ +0.06%	12/8/2016
БАЙГАЛИЙН ХИЙ	NGA	Mmbtu	3.578	▼ -0.69%	12/8/2016
НҮҮРС (NYMEX)	QZA	тонн	330.85	▼ -0.23%	12/8/2016
НҮҮРС (NEW CASTLE)	XWA	тонн	77.45	▼ -1.96%	12/8/2016
ЭЛСЭН ЧИХЭР	SBA	фунт	0.197	▲ +0.56%	12/8/2016
БУДАА	RRA	центнер	9.87	▼ -0.6%	12/8/2016
БУУДАЙ	WA	бушель	406.75	▲ +1.43%	12/8/2016
КАКАО	CCA	тонн	2324	▼ -1.44%	12/8/2016
КОФЕ	KCA	фунт	1.417	▼ -0.21%	12/8/2016

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.

Тэнцвэртэй мэдээллийг Танд

FT The New York Times

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АНГИЛАЛД 5 КОМПАНИЙН НИЙТ 8,652 ШИРХЭГ ХУВЬЦАА 9,837,964 ТӨГРӨГӨӨР АРИЛЖИГДСАН БАЙНА.				
АПУ ХК	APU	368.64	▲ 1.18%	12/9/2016
ГОВЬ ХК	GOV	10530	▼ -2.77%	12/9/2016
ДАРХАН НЭХИЙ ХК	NEH	19000	◀▶ 0.00%	12/9/2016
СҮҮ ХК	SUU	126.93	▼ -2.03%	12/9/2016
ТАЛХ ЧИХЭР ХК	TCK	18110	▲ 0.06%	12/9/2016
АНГИЛАЛД 12 КОМПАНИЙН НИЙТ 3,491 ШИРХЭГ ХУВЬЦАА 6,270,709 ТӨГРӨГӨӨР АРИЛЖИГДСАН БАЙНА.				
БАГАНУУР ХК	BAN	2056	▲ 2.80%	12/9/2016
Э-ТРАНС ЛОЖИСТИКС ХК	ETR	93.7	▼ -0.34%	12/9/2016
ГУТАЛ ХК	GTL	12500	▼ -4.51%	12/9/2016
ЖЕНКО ТҮР БҮРО ХК	JTB	65.9	▲ 9.34%	12/9/2016
МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК	MSH	679	▲ 12.23%	12/9/2016
МАТЕРИАЛИМПЕКС ХК	MIE	7500	▼ -7.41%	12/9/2016
МОНГОЛ ШУУДАН ХК	MNP	325.41	▼ -4.85%	12/9/2016
РЕМИКОН ХК	RMC	53.99	▼ -3.59%	12/9/2016
ШАРЫН ГОЛ ХК	SHG	2726	▼ -5.02%	12/9/2016
ШИВЭЭ ОВОО ХК	SHV	2650	▼ -7.70%	12/9/2016
ТАВАН ТОЛГОЙ ХК	TTL	3159	▼ -5.95%	12/9/2016
УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР ХК	UID	537	▲ 4.88%	12/9/2016

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
NASDAQ COMPOSITE	CCMP	5393.762	+60.76	▲ +1.14%	12/8/2016
DAX INDEX	DAX	11013.01	+26.32	▲ +0.24%	12/8/2016
TORONTO STOCK EXCHANGE	SPTSX	15237.75	+111.95	▲ +0.74%	12/8/2016
S&P/ASX 200	AS51	5543.635	+65.54	▲ +1.2%	12/8/2016
S&P 500	INX	2241.35	+29.12	▲ +1.32%	12/8/2016
SHANGHAI COMPOSITE	SHCOMP	3215.366	-6.88	▼ -0.21%	12/8/2016
DOW JONES INDUSTRIAL AVERAGE	INDU	19549.62	+297.84	▲ +1.55%	12/8/2016
TOP 20	MSETOP	11089.34	-86.04	▼ -0.77%	12/8/2016
FTSE 100	UKX	6897.45	-4.78	▼ -0.07%	12/8/2016
HANG SENG	HSI	22861.84	+60.92	▲ +0.27%	12/8/2016
NIKKEI 225	NKY	18765.47	+268.78	▲ +1.45%	12/8/2016